

ХӨВСГӨЛ ХӨДӨЛГӨӨН: 1988-1991⁴³

Ч.Тамир доктор дэд проф.
МУИС-ийн ШУС-ийн дэд захирал
Orcid: 0000-0001-5600-2409

Abstract: During mid 1987, influenced by Perestroika in the Soviet Union, writers from Soviet Siberia, together with Japanese journalists and writers, started an environmental movement to protect Lake Baikal. The movement drew writers and journalists from the Republics of Armenia and Kazakhstan, which were part of the Soviet Union at that time, forming the international environmental movement "Roof". Inspired by these, writer Baldorj Tserendorj published an article entitled "Mother Sea on the Death Row" with the request of newspaper "Unen". The article was so inspiring that in July 1988, Mongolian journalists and writers formed "Khuvsgul Movement" as a branch of "Baikal Movement". In the fall of 1989, the students of the National University of Mongolia organized a movement to protect Lake Khuvsgul. This article referenced the archive materials of the National Archives of Mongolia, the former Mongolian People's Revolutionary Party, old daily newspapers, official memoirs of people who participated in the event, and interviews with them. It could be concluded that the public protests to protect Lake Khuvsgul played a critical role in organization of the first demonstration in Mongolia and formation of Mongolian Democratic Union.

Keywords: baikal movement, khuvsgul movement, public protest

1. Удиртгал

Нийгмийн хөдөлгөөний онолын дагуу бол “өөрчлөн байгуулалт” нь эсэргүүцэл үүсэх “улс төрийн боломж”-ийг (political opportunity) бий болгосон бол зөвлөлт ба монголын сэтгүүлчдийн холбоо ба сүлжээ нь “дайчилгаа явуулах нөөц” (resource mobilization) үүсгэсэн, мөн өөрчлөн байгуулалтаас үүссэн хүлээлт, нийгмийг өөрчлөх хүсэл эрмэлзэл нь (issue framing) асуудлын хүрээг үүсгэж өгчээ (Doug Adams., John D. McCarthy., Mayer N.Zald 1996, 2-5).

ЗХУ-д 1985 оноос өрнөсөн “өөрчлөн байгуулалт” нь социалист аж үйлдвэржилт-хотжилт, төлөвлөлтийн сөрөг үр дагавар болсон байгаль орчны бохирдлын сэдвийг ил тод дэлгэж, байгаль орчныг хадгалах, хамгаалах, нөхөн сэргээх үзэл баримтлалыг аяндаа боловсрогдоход хүргэжээ. Наяад оны дундаас хойш сэтгүүлч, зохиолчид намын өөрчлөн байгуулалтын чиг шугамын дагуу социалист ил тод байдлын гортиг дотор байгаль орчны хамгаалах асуудлыг хөндсөн бүтээл туурвил хэвлэж эхлэв. Ил тод байдлын ачаар “Хэвлэл утга зохиолыг хянах газар” (ХУЗХГ) татан буугдаж намын албан ёсны хэвлэлүүд сонинууд байгаль орчны асуудлыг тусгай сэдэв болгон дэвшүүлж, олон нийтэд мэдээлэл өгч байв. Иргэдийн байгаль орчны талаар шүүмжилсэн захидлыг олноор нь сонин нүүрэндээ хэвлэх болов. Үнэхээр ч наяд оны олон нийтийн эсэргүүцлийн чухал сэдэв бол байгаль орчныг хамгаалах байсан бөгөөд энэ нь өөрөө уул уурхай, зохистой бус таван жилийн төлөвлөгөө, хүнд суртал, аж үйлдвэржилт-хотжилтоос үүссэн сөрөг бүхнийг эсэргүүцэж байсан юм.

Зөвлөлтийн шууд нөлөөгөөр МАХН-ын Төв хорооны албан ёсны хэвлэл “Үнэн” сонин сэтгүүлч Ц.Балдоржийн “Далай ээж цаазын тавцанд” гэсэн өгүүллээс эхлэн Монголын сэтгүүлч ба зохиолч, залуучууд, оюутнууд “Хөвсгөл нуурыг хамгаалах хөдөлгөөн” нь ЗХУ-ын Байгалийн хөдөлгөөний салбар болж үүсэж 1988-1991 он хүртэл гурван жил орчим идэвхтэй ажиллажээ. Хөдөлгөөн нь үндэсний хэмжээнд иргэд хөдөлмөрчдийн дэмжлэгийг өргөн авч байсан хэдий ч сэтгүүлч зохиолч нар болон оюутан залуучууд гэсэн хоёр бүлгээс цөм нь бүрдэж байжээ. Сэтгүүлч, зохиолч нарын бүлэг нь гол төлөв “Үнэн” болон бусад сонинд суурилсан, хүн байгалийн харьцаа, байгаль орчны мөн чанарыг ойлгох, ухаарах хамгаалах сэдвээр бүтээлээ туурвидаг сэхээтнүүд байв. Тэд байгаль хамгаалах олон улсын сүлжээний схемээр ажиллаж байсан бол, оюутны хөдөлгөөн нь МУИС, УБДС, ПДС зэрэг сургуулийн оюутнууд нь манлайлж ханын сонин гаргах, гарын үсэг зурсан эсэргүүцлийн захидал бичих, уулзалт хийх, жагсаал цуглаан хийхийг санаачилдаг байжээ. “Хөвсгөл нуурыг

⁴³ Уг өгүүлэл нь хоёр хэсэгтэй бөгөөд дараагийн дугаарт үргэлжлэл хэсэг нь гарна.

хамгаалах хөдөлгөөн” нь дараагийн улс төрийн бүлгэм “Шинэ үе”, мөн Ховдын анхны жагсаал, Эрдэнэтийн анхны цуглаан, МоАХ үүсэхэд хүртэл нөлөө үзүүлсэн нь судалгааны материалуудаар нотлогдож байна. Байгаль орчныг хамгаалах уг хөдөлгөөн нь цаашдаа монголд ногоон нам үүсэж ногоонтнуудын хөдөлгөөн үүсэх суурь болжээ.

2. Сэдвийн судлагдсан байдал.

Юуны түрүүнд Хөвсгөлийн хөдөлгөөн нь маш бага судлагдсан гэдгийг дурдах хэрэгтэй. Архивын материал үзэхэд Байгаль орчны яамны 1989 оны тайлан холбогдох материалуудад энэ тухай өгүүлсэн зүйл алга⁴⁴. АИХ-ын дарга, МАХН-ын Ерөнхий Нарийн бичгийн дарга (ЕНБД) Ж.Батмөнхийн “Хүч хэрэглэж хэрхэвч болохгүй” хэмээх бүтээл 2001 онд хэвлэгдэхэд Хөвсгөл нуурын фосфоритын⁴⁵ ордын талаар, мөн Хөвсгөл нуурыг хамгаалах хөдөлмөрчид, сэхээтнүүдийн эсэргүүцлийн талаар тодорхой өгүүлсэн нь сонирхолтой (Батмөнх 2001). Үүний дараа У.Баркманн “1989 оны 11-р сард МУИС-ийн хэсэг оюутнууд “Хөвсгөл нуурыг хамгаалах хөдөлгөөн”-ийг үүсгэн байгуулав. Тэд Хөвсгөл нуураас холгүй фосфоритын ордыг ашиглах үйлдвэр байгуулах тухай мэдээллийг олж аваад энэхүү байгууламжаас учрах ёстой хэмжээлшгүй их хор хохирлыг тойрон гарахын төлөө анхнаасаа л түүнийг байгуулахгүй байх шийдвэр гаргахыг Засгийн газраас шаарджээ” гэжээ (Баркманн 2008, 64). Мөн тухайн үед Байгаль орчныг хамгаалах сайд байсан У.Мавлетийн “Хөдөлмөрөөр жигүүрлэсэн он жилүүд” хэмээх дурсамжийн ном 2008 онд хэвлэгдсэн. Уг номд Хөвсгөл нуурыг хамгаалахтай холбоотой болсон үйл явдлууд зарим баримтуудыг нээж харуулснаараа онцлог юм. (Мавлет, Хөдөлмөрөөр жигүүрлэсэн он жилүүд 2008). Ц.Балдоржийн ““Далай ээж” маань цаазын тавцанд хэмээх түүний нийтлэлийн эмхэтгэл 2008 онд хэвлэгдсэн нь судалгааны ажилд чухал хэрэглэгдэхүүн болно (Балдорж, "Далай ээж" маань цаазын тавцанд 2008). 2019 онд Т.Лхагва нарын багийн “Ардчиллын замнал: алдаа-оноо, сургамж-сорилт” хэмээх V боть номыг туурвисан, тус бүтээлийн I бүлэгт “Хөвсгөл нуурыг хамгаалах хөдөлгөөн” байгуулагдсан тодорхой мэдээ баримтыг оруулжээ (Лхагва 2019, 35-38). Мөн Д.Сүхбаатар, С.Эрдэнэцогт нарын “Монголын дээд боловсрол, оюутны байгууллагын түүхэн хөгжлийн тойм ба цагаан морин жилийн хувьсгал” хэмээх бүтээлд Хөвсгөл нуурыг хамгаалах хөдөлгөөний талаар товч дурдагдсан (Сүхбаатар, Д., Эрдэнэцогт, С 2019). Товчхондоо “Хөвсгөл нуур”-ыг хамгаалах хөдөлгөөн дэлгэрэнгүйгээр судлагдаагүй байгаа.

3. Зөвлөл Холбоот Улсын Байгалийн хөдөлгөөн.

Наяад оны эхнээс байгаль орчны хөдөлгөөнүүд дэлхийн өнцөг булан бүрд байгуулагдаж эхэлжээ. ЗХУ болон социалист лагерийн улс орнууд ч энэ давалгаанд татагдан оров. ЗХУ-ын хувьд Сибирийн асар их баялгийг ашиглах таван жилийн төлөвлөгөө хатуу ширүүнээр хэрэгжиж зөвлөлтийн аж үйлдвэрийн бэлгэ тэмдэг болж байв. Энэ бүхэн нь нөгөө талаас байгаль орчныг бохирдуулан доройтуулж, уламжлалт тосгоны тариачны “жинхэнэ орос” амьдрах хэв маягийг өөрчилж тосгоны амьдрал алга болох нь гэсэн “гутранги” сэтгэлгээг үүсгэж байв. Тиймээс социализмыг зөвхөн хүнд аж үйлдвэрийн нүдээр бус байгаль орчныг сүйтгэгч, хордуулагч, эргэн сэргээгдэхгүй болгож байгаа гэсэн шүүмжлэлт нүдээр харах болов. 1989 оны 6-р сард ЗХУ-ын Ардын Депутатуудын конгресс дээр ардын депутат А.В.Яблоков ЗХУ-ын нийт хүн амын 20 хувь нь экологийн хувьд сүйрэл болсон газарт амьдарч байна, 35-40 хувь нь экологийн хувьд таатай биш нөхцөлд амьдарч байна гэж мэдэгдэж байжээ (Zakharchenko 1990, 458).

Томас Райн энэ цаг үеийг 1985 оноос өмнө ямар ч зохиолч байгаль орчны асуудлаар үзэл бодлоо улс төрийн үйл ажиллагаатай шууд холбож байгаагүй гэж онцолсон (Raineу 1991). Дараахан нь Сибирийн гаралтай, Сибирт амьдардаг уул, ус, нуур, ой тайгаа хамгаалах үзэл сэтгэлгээгээр зохиол бүтээлээ туурвидаг зохиолчдын бүлэг үүсэв. Уг бүлгийн хамгийн том төлөөлөгч нь далаад оны дунд

⁴⁴ (Хөмрөгний дугаар 407, Дансны дугаар 1 ХН дугаар 35, он 1989 38-р хуудас)

⁴⁵ Ерээд оноос өмнөх болон дараах ном зохиолуудад “фосфорит” болон “фосфор”-ын гэж хоёр янзаар бичдэг. Чухам ямар бүтээлээс авснаас хамааран бичсэн хэлбэрээр нь оруулав. Дээрх хоёр үг ижил утгатай болно.

үеэс⁴⁶ алдартай болсон, 1984 онд Ленины одонгоор шагнагдсан, 1985 оны “Пожар” буюу “Түймэр” хэмээх өгүүлэл бичсэн зохиолч Валентин Распутин юм. В.Распутин 1986 оны 2-р сарын 17-ны өдөр “Байгаль бидэнд ганц” (Байкал у нас один) хэмээх шүүмжлэлт өгүүлийг “Известия” сонинд хэвлүүлжээ. Өгүүлэлд тэрээр 1966 оноос хойш Байгал нуурын эрэгт үйл ажиллагаа явуулж байгаа Картон цаасны үйлдвэрийн удирдлагууд, мөн байгаль нуурыг хамгаалах талаар тухайн үеийн Зөвлөлтийн Ой, цаасны үйлдвэрийн сайдтай сайдтай хийсэн үр дүнгүй уулзалтын талаар нийтэлжээ. Өгүүлэл хэвлэгдсэний дараа зөвлөлтийн олон мянган хөдөлмөрчдөөс захидал сонины газарт ирсэн байна (Цэдэн-Иш 1990). Картон цаасны үйлдвэр нь ус ихээр хэрэглэдэг бөгөөд далайгаас авч хэрэглэсэн усаа буцаагаад далайд юүлдэг нь далайг бохирдуулж байжээ. Өгүүлэл гарсны дараа найм хоногийн дараа ЗХУКН-ын XXVII их хурал эхлэх гэж байжээ. Мөн тухайн цаг үед ЗХУ-ын Украйнд Чернобылийн атомын цахилгаан станц хүний үйл ажиллагаанаас хамааран осолд орж цөмийн гамшгийг бий болгосон нь байгаль орчны хөдөлгөөнүүдийн сэдэв болжээ (Zaharchenko 1990, 460). Үүний дараа 1986 онд В.Распутин “байгаль хамгаалах сэдвээр туурвидаг мэргэжил нэгт нөхдийн урилгаар Японд очиж японы зохиолч, сэтгүүлч нартай холбоо тогтоож японы баримтат киноны нэрт төлөөлөгч үндэсний болон олон улсын уралдааны удаа дараагийн шагналтан Нориаки Цутимото нартай уулзжээ. Нориаки Цутимото нь “Минамата дахь химийн “Тиссо” пүүс зөвхөн олз ашиг хайн далайн эрэг орчны усыг хордуулснаас пүүсийн ажилчдын хүүхдүүд сэтгэл мэдрэлийн аюулт өвчнөөр өвдөн хөл гар нь татганан, хүн төрхөө алдаж, муур нохой мэт болоод хэдхэн сарын нас эцэслэж байгааг сэтгэл шимширтэл дүрсэлсэн” Минамата-өвчний хорин жилийн түүх”⁴⁷ хэмээх баримтат киногоороо дэлхийд алдартай болсон зохиолч¹ юм (Балдорж, Хүйн холбоотой Хөвсгөл, байгал хоёр 1989). Японд тэд дараа жил Байгалын эрэгт уулзан гол мөрөн, нуур усаа зөвхөн хайрлаж халаглах биш харин хувь заяаных нь төлөө хамтарч тэмцэх хөдөлгөөний эс үүсвэрийг тавих талаар японы зохиолчидтой тэр үед тохиролцсон” (Балдорж, Хүйн холбоотой Хөвсгөл, байгал хоёр 1989). Зөвлөлтийн хэвлэлд нийтлэгдэж байсан Байгалийн хөдөлгөөний гол төлөөлөгчдийн бүтээлийг Монголын уншигчид өргөнөөр уншиж хэлэлцүүлгийн үзэл санаанд нь автаж байв. Тухайн цаг үед орос хэл нь сэхээтнүүдийн үндсэн хэл байсан, мөн зарим бүтээлийг нь сорчлон монгол хэлээр орчуулан хэвлүүлж байв. В.Распутины 1985 оны “Пожар” буюу “Түймэр” хэмээх өгүүлэл гарсан, өгүүлэлд социализмын бүтээн байгуулалт, үйлдвэржүүлэлтийн хатуу төлөвлөгөө нь байгаль орчин тэр дотроо Сибирийн уул ой тайгыг хэрхэн хайр найргүй, явуулын шинжтэйгээр устгаж байгааг мөн хүн өөрөө энэ төлөвлөгөөний нэг хэсэг болж өөрийн мөн чанарыг хэрхэн алдаж хүнд үйлдвэржилтийн эрэг шураг болж байгаль эхээсээ хэрхэн тасарч байгаа гэдгийг харуулснаараа социализмын үед алдаршсан⁴⁸ юм. Улмаар Виктор Астафьевын “Гунигт явдал” хэмээх роман нь 1986 онд хэвлэгдэж цаг үеийнхээ залуучуудын эсэргүүцлийн үзэл санааг илэрхийлсэн унших дуртай бүтээл болов. Романд Сибирийн тосгон гацааны жирийн тариачны амьдралыг ажил хэрэгч хөдөлмөрч байдал, эгэл жирийн байгаль орчиндоо зохицсон байдал, энгийн даруу төлөв нь социализмын үеийн хайр найргүй төлөвлөлт, хааш яаш гүйцэтгэл, харгис хатуу хотжилт, хотын хүмүүсийн залхуу, хээнцэр тансаг байдал, ялгарч бусдаасаа тасрахын төлөөх гэмцэлтэй харьцуулан харуулжээ. Товчоор бол социалист нийгэм дэх хөдөөгийн жирийн тариачдын амьдралын ялгаа, хот-хөдөөгийн ялгаа, хотын соёл нь хэрхэн тосгоны жирийн тариачны амьдралыг хэмлэж устгаж байгааг илэн далангүй өгүүлсэн. “Гунигт явдал” хэмээх романыг Р.Ганбат 1990 онд монгол хэлнээ орчуулж хэвлүүлжээ.

Тухайн сэдэвтэй холбоотой өөр нэг чухал бүтээл бол Зөвлөлт-Киргизийн нэрт зохиолч Чингиз Айтматовын “Цаазын тавцан” хэмээх бүтээлийг Г.Аким орчуулж 1989 оны 6-р сард хэвлүүлжээ. Тус зохиолын орчуулагчийн төгсгөлийн үгэнд “ЗХУ-д болж байгаа өөрчлөн байгуулалт шинэ сэтгэлгээ, ил тод байдал гэсэн бахдам сайхан үйл явцаар гарч ирсэн энэ роман” нь гээд цааш нь “Байгаль хүн хоёрын харилцаа, хүнд итгэх итгэл, шүтлэгт хандах байдал, хүн төрөлхтөн өөрийгөө хөнөөх аюул, орчин үеийн хүнд суртал гээд олон олон асуудлыг уг романд сөхсөн байна” гэжээ (Айтматов 1989,

⁴⁶ «Прощание с Матёрой» хэмээх бүтээлээ 1976 туурвисан.

⁴⁷ 1971 онд “Minamata: The Victims and Their World” хэмээх баримтат киноны зохиолч. 1975 онд “The Shiranui Sea” хэмээх киног бүтээсэн. [Minamata: The Victims and Their World - YouTube](#)

⁴⁸ В.Распутины “Дурсаж яваарай”, “Эцсийн хугацаа”, “Агуулах шатахад”⁴⁸ гэдэг гурван туужийг С.Бадраа, Д.Даваажав нар монгол хэлнээ орчуулж “Дурсаж яваарай” нэрээр 1990 онд хэвлэсэн (В.Распутин 1990). ЗХУ-ын зохиолч Виктор Астафьев нь 1977 онд “Хаан загас” хэмээх бүтээлээрээ алдаршсан юм. Түүний “Хаан загас” романыг Ц.Гомбосүрэн монгол хэлээр 1982 онд орчуулсан.

309). Мөн ЗХУ-ын Хабаровскийн хязгаарын нэрт зохиолч Анатолий Буйловын “Их нүүдэл” хэмээх бүтээлийг Ц.Гомбосүрэнгийн орчуулгаар 1989 онд хэвлэв. А.Буйловын Монгол уншигчдад зориулан бичсэн өмнөх үгэнд “Миний бүтээлийн сэдэв бол Хүн Байгалийн харьцаа, Хүн хүнтэйгээ харьцах асуудал юм. Манай гариг дээр Энх тайвныг сахин хамгаалах, Байгаль дэлхийгээ хайрлан хямгадах эгзэгтэй хур чухал хоёр асуудал өнөөдөр бидний өмнө тулгараад байна” гэжээ (Буйлов 1989, 4). Мөн Байгалийн хөдөлгөөний төлөөлөгч Казахстаны яруу найрагч Олжас Сулейменовын “Аргамаг” хэмээх шүлгийн түүврийг Ж.Лхагва монгол хэлнээ орчуулан 1990 онд гаргасан. Монголд болсон зохиолчдын хорооны хэлэлцүүлэгт байгаль орчны сэдвээр бичдэг Д.Цэвэгмид зэрэг монголын зохиолчид ч өөрчлөн байгуулалтын үед “байгаль орчныг ялангуяа амьтны аймгийг хамгаалах, арвижуулах, амьтныг энэрэн нигүүлсэх нинжин сэтгэлийн талаар” бүтээлээ туурвина гэж амлаж байв (Уран бүтээл, өөрчлөн байгуулалт огноо байхгүй).

Дээр дурдсан бүхэн нь нүүдэлчин амьдралтай монголчуудын хувьд байгаль орчны асуудлыг эргэн сөхөх, түүх уламжлалаа сэргээх, ер нь үйлдвэржилт-хотжилтын сөрөг үр дагаврыг эргэцүүлэхэд нөлөө үзүүлж байгаль орчныг хамгаалах эсэргүүцэлд хүргэсэн нь дамжиггүй.

Зөвлөлтийн зохиолчид 1986 оны Зөвлөлтийн зохиолчдын хорооны VI их хурлаас байгаль орчныг хамгаалах тэмцлээ албан ёсоор эхлүүлснээ зарлав. Ингэж зөвлөлтийн зохиолчдын хороо нь өөрчлөн байгуулалтын үед байгаль орчныг хамгаалах албан бус санаачилгыг үүсгэхэд чухал үүрэг гүйцэтгэжээ. “Ил тод байдал”, “ардчилах” үйл явц нь ЗХУ-ын доторх бүгд найрамдах улсуудад байгаль орчны чиглэлийн албан бус бүлэг, санаачилгын хөдөлгөөнийг үүсгэж улмаар зохион байгуулалт бэхэжсэн хөдөлгөөнүүд улс төрийн шаардлага тавих дараагийн алхам руугаа явж байв. 1986-1987 онууд “байгаль орчны төлөө” сэтгэлтэй Латвийн сэтгүүлч⁴⁹ нар голын (Daugava River) эрэг дээр усан цахилгаан станц барихыг эсэргүүцэж олон нийтийн цуврал жагсаал эхлэв (Dawisha 1997, 255). 1987 оны хавраас Эстонийн Тарту Их сургуулийн оюутнууд манлайлан байгаль орчны эсэргүүцлийг хийж эхэлсэн (Dawisha 1997, 345). 1987 оны 8-р сарын 23-ны өдөр Молотов-Риббентропын гэрээний ойн өдөр томоохон жагсаал цуглаан хийж эхэлсэн 1988 оноос “Эстонийн Ард түмний фронт” (Estonian Popular front) байгуулагдсан байв (Dawisha 1997, 345). Зүүн Европын социалист лагерийн орнууд Болгар, Румын зэрэг орнуудад ч гэсэн экологийн хөдөлгөөнүүд үүсээд байв (Juan J.Linz., Alfred Stepan 1996, 332)

ЗХУКН-ын Төв хорооны албан ёсны хэвлэл “Правда” сонинд 1987 оны 3-р сарын 11-ны дугаарт “Ажилчин хүн улсын эрх ашгийн үүднээс сэтгэж чадахгүй байна гэж үү” гэсэн нийтлэл гарсан байна. 1987 оны 3-р сарын 14-ны өдөр төрийн шагналт зохиолч Валентин Распутин ЗСБНХУ-ын социалист хөдөлмөрийн баатар болов. Үүний дараа В.Распутины “Байгаа юмаа...” (Что имеем... Байкальский пролог без эпилога) гэсэн нийтлэл нь “Правда” сонинд 1987 оны 5-р сарын 11-ны өдөр нийтлэгдэж олныг шуугиулж байв. Тэрээр “Хойд зүгийн болон Сибирийн гол мөрний голдирлыг буцааж эргүүлэх тэмцэл олон жил үргэлжилсэн. Залгамж үеүдийн хооронд эзэгнэх хууль зүйн харьцааг хүн төрөлхтөн хэзээ нэг цагт заавал тогтооно. Одоогийн юмыг эзэгнэж байгаа нь өнгөрсөн болон ирээдүйн бүхнийг эзэгнэгч биш ээ. Тэр аяар нь урвуулж хөрвүүлэх хүч чадалтай болсон эсэхийг шалгахын тулд хүнд газар шороо заяагаагүй. Хүн тийм чадалтай болсон” гээд улмаар Байгал нуурын эрэг дээр байгуулсан үйлдвэрийг зогсоох мөн Ой цаасны яамны төлөвлөгөөгөө биелүүлэхийн тулд байгаль орчныг сүйтгэх шинэ төслийг зогсоох, ЗХУ-ын хэмжээнд гол нууруудыг хамгаалах шаардлагатайг өгүүлжээ.

Дээрх тэмцлийн үр дүн болж 1987 оны 4-р сарын 13-нд ЗХУКН-ын Төв хороо, ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ““1987-1995 онд Байгал нуурыг байгалийн баялаг усыг ухаалаг ашиглах ба хамгаалалтыг хангах арга хэмжээг авах тухай”⁵⁰ шийдвэр гаргаж тэр үеэр нуурын сав газрын байгаль орчныг хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх талаар урьд өмнө гаргасан шийдвэрүүдийг биелүүлээгүй буруутай хүмүүсийн хариуцлагын тухай асуудлыг ЗХУКН-ын Төв хороонд авч хэлэлцсэн байна” гэжээ (Балдорж, Далай ээж маань цаазын тавцанд 1987).

⁴⁹ Өөрчлөн байгуулалтын үед хамгийн анхны албан бус байгууллага болох “Латвийн Ард түмний фронт” (Latvian Popular front) хэмээх байгууллага нь 1988 оны эхээр үүсчээ (Dawisha 1997, 255). Литви нь эсэргүүцлийн баялаг уламжлалтай орон бөгөөд өөрчлөн байгуулалтын үеийн анхны хүчтэй эсэргүүцэл нь 1987 оноос Молотов-Риббентропын гэрээг эсэргүүцсэн гудамжны жагсаал цуглаан зохион байгуулж байв. Улмаар Горбачевийн зөвшөөрөлтэйгөөр Литвийн албан бус бүлэг, Эстон ба Латвийн ард түмний фронтой нийлж 1988 оны 6-р сард (Sajudis) хэмээх байгууллагыг үүсгэн байгуулжээ (Dawisha 1997, 295).

⁵⁰ “О мерах по обеспечению охраны и рационального использования природных ресурсов бассейна озера Байкал” гэсэн шийдвэр гарсан.

“1987 оны 8-р сарын нэгэнд ЗСНХУ-ын зохиолчдын хороо эрхлэн Эрхүү мужийн зохиолчдын ордонд зөвлөлт, японы зохиолчдын “Экологи-энхтайван, экологи-утга зохиол” сэдэвт уулзалтыг зохион байгуулсан юм”. Байгалийн эрэгт “Байгалийн хөдөлгөөнийг санаачлагчид” нь ЗХУ-ын талаас Валентин Распутин, Владимир Крупин, Василий Белов, Виктор Астафьев, Зорий Балаян⁵¹ нар, Японы талаас зургаан зохиолч үүнд Хироси Нома, Нобуюки Накамото нарын зохиолчид байв (Балдорж, Хүйн холбоотой Хөвсгөл, байгал хоёр 1989). Ингэж 1987 онд Байгалийн олон нийтийн хөдөлгөөн байгуулагдсаныг “Литературная газета” сонинд мэдээлжээ. Дээр дурдсанаас гадна О. В. Волков, Г. И. Галазий, О. К. Гусев, Ф. Н. Таурин, В. А. Чивилихин, М. А. Шолохов, А. Л. Яншин зэрэг олон зохиолчид хамтран “Байгаль далайг хамгаалах” сайн дурын үүсгэл санаачилгыг дэмжжээ. Байгаль “хөдөлгөөнийг үндэслэгчид нь гаргасан мэдэгдэлдээ цэвэр уст нуур болон ундааны усны бүх эх үүсвэр нь дэлхийн улс түмнүүдийн баялаг бөгөөд тэдгээрийг зүй зохистой ашиглах нь нийт хүн төрөлхтний үйл хэрэг” гээд уран зохиолчдын жил бүр зохиох “Байгалийн хөдөлгөөн” уламжлалт уулзалтад орон орны зохиолчдыг оролцохыг урилаа (Балдорж, Далай ээж маань цаазын тавцанд 1987).

1988 оны 1-р сард ЗХУ-ын Байгалыг хамгаалах Улсын хороог анх удаа шинээр бие даалган байгуулсан гол зорилго нь байгаль орныг хамгаалах агентлаг, яамд, улсын хорооны дунд зохицуулалт хийх чиг үүрэгтэй юм (Zaharchenko 1990, 472). ЗХУ-ын хувьд 1945-1953 он хүртэл “Модны аж үйлдвэрийн яам” байсан ч байгаль орчныг хамгаалах төрийн байгууллага байсангүй, 1989 оны 7-р сарын 17-ноос 1991 оны 8-р сарын 24 хүртэл “Байгаль орчныг хамгаалах төрийн зөвлөл”-ийн сайдаар 1988-1991 он хүртэл Виктор Филоненко нар ажиллаж байжээ⁵².

1988 оны намар Армены Севан, Казахстаны Балхаш нууранд II уулзалтаа хийжээ. Уулзалтанд Зөвлөлтийн зохиолчдоос гадна Японы талаас арван зохиолч, телевизийн “Асахи” пүүсийн зургаан сурвалжлагчид, Армен ба Казахстаны зохиолч сэтгүүлч, мөн монголын Хөвсгөл, Казакстаны Балхаш нуурыг хамгаалах хөдөлгөөнийхөн нэгджээ (Балдорж, Хүйн холбоотой Хөвсгөл, байгал хоёр 1989). Армений Севан нуурын эрэг ойр орчимд цахилгаан станц байгуулж зэс, цайр, никель, кобальт, мөнгөн ус зэрэг химийн бодис голуудын урсгал даган орж ёроолд нь хүнд металлын нэгдэл үүсэхэд хүрчээ (Балдорж, Хүйн холбоотой Хөвсгөл, байгал хоёр 1989). Улмаар цахилгаан станцыг хаажээ. Казахстаны Балхаш нуурын тухай Ц.Балдорж “Балхаш нуурын эрэгт 50 жилийн өмнө байгуулсан зэсийн уурхай, үйлдвэрийн үйл ажиллагаас болоод нуурын загас үхэж, эмэгтэйчүүд, хүүхдийн өвчлөл ихэсч эргэн тойрных нь байгаль орчин доройтож байна” гээд “Хөдөлгөөнийхөн Казахстаны Семиплатинскийн атомын дэлбэрэлт хийх түшиц газрын тэндхийн хөдөлмөрчид хэрхэн эсэргүүцэж байгаатай танилцсан бөгөөд 1989 онд Бүгд найрамдах Казахстан улсын Дээд зөвлөл түүнийг хаах шийдвэр гаргажээ” гэжээ (Балдорж, “Далай ээжийг” цаазлахаар зэхэж байна 1989).

1988 онд ЗХУ-д “Социал-Экологийн Холбоо, Экологийн Холбоо, Ногоон хөдөлгөөний бүх холбоод зэрэг албан бус байгууллага санаачилгын байгууллагууд үүссэн бөгөөд байгаль орчныг хамгаалах, эргэн сэргээх, ан амьтны эрхийг хамгаалах олон нийтийн анхаарлыг байгаль орчны бохирдолд сүйрэлд хандуулах зорилготойгоор үүсжээ” (Zaharchenko 1990, 460).

1989 оны 10-р сарын 12-18-ны өдрүүдэд Японы Бива нуурын хөвөөнөө “Байгалын хөдөлгөөн”-ий гуравдах уулзалт болж зөвлөлт, монгол, японы Байгал, Бива, Хөвсгөл, Арал, Балхаш, Севан, Волга гэсэн зургаан нуур нэг голын төлөөлөгчид оролцжээ. Төлөөлөгчид Бива нууртай танилцаж дөчин жилийн өмнө хүн шууд уудаг байсан ус химийн үйлдвэрүүд олноор барьж фосфор, азотын агуулга ихэссэний улмаас бохирдож хүн цэвэршүүлэхээс наана уух аргагүй болтлоо бохирдсон учир шалтгааны хэлэлцжээ (Балдорж, Далай ээжтэй золгохын ерөөл тавив 1989). 1989 оны зун Распутин СССР-ын Ардын депутатуудын их хурлын гишүүнээр сонгогдсон.

1989 оны 10-р сарын байдлаар “фосфоритын орд газрыг ашиглах, боловсруулах зөвлөлтийн технологи харьцангуйгаар хоцрогдсон, байгаль орчинд хор нөлөөтэй, эдийн засгийн хувьд ашиг муутай байгаа учир Эстони, Дундад Ази, Зөвлөлт Буриадад тийм ордуудыг ашиглаж байсныг

⁵¹ Зорий Балаян Зөвлөлт-Армений зохиолч, нийгэм улс төрийн зүтгэлтэн. 1975-1990 онд хүртэл “Литературная газета” сонинны Армен дахь сурвалжлагч бөгөөд Севан нуурыг хамгаалахын төлөө тэмцэж 1989 онд ЗСБНХУ-ын ардын депутат болжээ. Байгалийн хөдөлгөөний гишүүн (Балдорж, Хүйн холбоотой Хөвсгөл, байгал хоёр 1989)

⁵² ЗХУ-д 1991 оны 3-р сарын 20-ны өдөр “Байгаль орчин ба байгаль орчныг хамгаалах яам” гэж байгуулсан бөгөөд уг яам 1991 оны 8-р сарын 26-ны өдөр хүртэл нийтдээ 157 өдөр л үйл ажиллагаа явуулсан түүхтэй.

зогсоож эсвэл эзэмших гэсэн төлөвлөгөөг хүчингүй болгосон байна” (Балдорж, "Далай ээжийг" цаазлахаар эхэж байна 1989).

1989 оны 11-р сарын 27-ны өдөр ЗСБНХУ-ын Дээд зөвлөл “Улс орны экологийн нөхөн сэргээлт хийх яаралтай арга хэмжээ” хэмээх тогтоолыг баталжээ (Zaharchenko 1990, 459)

1990 оны 8-р сарын эхээр Байгалийн хөдөлгөөн уулзалтыг Хөвсгөл нуурын дэргэд хийжээ. Байгалийн хөдөлгөөний IV уулзалтад оролцогчид Хөвсгөл бол “Монголын ард түмний төдийгүй, бүх хүмүүн төрөлхтний үнэт баялаг мөн. Хөвсгөл шиг ус нь цэнгэг, орчин нь унаган төрхөөрөө нуур ус дэлхийд цөөхөн үлдсэн билээ. Түүнийг бид нийтээрээ хайран хамгаалах ёстой. Энэ зорилгоор хүн устай хэрхэн харилцахын жишиг болгож хүн төрөлхтөн нийтээрээ хамгаалах дэлхийн өвийн жагсаалтад оруулахыг “ЮНЕСКО”-д бид хандан хүсэж байна” гэж тодорхойлжээ (Мавлет, Хөдөлмөрөөр жигүүрлэсэн он жилүүд 2008, 98).

4. Иргэд хөдөлмөрчдийн идэвхжил.

Зөвлөлтийн эрдэмтэн зохиолчдын Байгал далайг хамгаалах тэмцлийн явцад нийтлэгдсэн нийтлэл захидал, ярилцлагуудыг Монголын сонинууд орчуулан хэвлэж байв. Эдгээр нийтлэлүүд нь зүй ёсоор монголын “ногоонтнууд”-ын идэвхийг сэргээж дайчилгаанд ороход хүргэв (Балдорж, Далай ээж маань цаазын тавцанд, 1987). 1987 оноос Хөвсгөл нуурын төлөө санаа зовсон монголын уншигчид Байгал хөдөлгөөнд нэгдэн орохыг уриалж шамдуулах болов (Балдорж, Далай ээжтэй золгохын ерөөл тавив 1989). Тухайлбал 1987 оны 2-р сарын 7-ны өдөр “Үнэн” сонины IV нүүрэнд экологи-агнуур судлалын группийн ахлагч Я.Дашийн “Далай ээжээ хамгаалъя” гэсэн өгүүлэл нийтлэгдэв. Тэрээр Хөвсгөл нуурын байгалийн цогцолбор, орчныг “Монгол орны уушги” гэж тодорхойлоод “Байгал нуурын усан тэжээлийн 60 орчим хувийг Хөвсгөл нуур, Сэлэнгийн сав газар өгдөг” гэж Байгалийн хөдөлгөөнтэй уялдуулсан байна. Даш цааш нь Хөвсгөл далайгаар шатахуун түлш тээвэрлэхийг хориглох, нуурын эрэгт байгаа Ханх, Хатгалын нефть агуулах нь байгаль орчинд эрсдэл учруулж байгаа, Хатгал Ханхын ой орчмыг хамгаалах зэрэг саналыг шууд дэвшүүлжээ. Хамгийн гол нь тэрээр цаашдын Эрдэнэт Мөрөнгийн төмөр зам, уул уурхайн олборлох үйлдвэл аж үйлдвэрийн төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах экологийн тэнцвэрийг алдагдуулахгүй байх асуудлыг тусгах шаардлагатайг байгааг сануулжээ. Монгол зөвлөлт хоёр орны хамтын ажиллагаанд ч гэсэн Хөвсгөл цогцолбор нь Байгал нуур, Ангар-Енисей мөрөн дээрх Сибирийн усан цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх нь “зөвлөлт, монголын эрдэмтдийн хамтарсан судалгаанаас” харагдаж байгаа учраас “ах дүү хоёр орны эрх ашиг, манай ирээдүй хойчийн эрх” ашгийг бодолцох хэрэгтэй гэжээ. Эцэст нь тэрээр Хөвсгөлийн фосфоритын сав газрын ордыг эзэмшихдээ байгаль орчныг хамгаалах судалгаа шинжилгээг хийх, тусгай хамгаалалтай болгож хадгалж Байгаль нуурын туршлагаас суралцахын чухлыг дурджээ (Я. Даш 187).

Зөвлөлт, монголын сэтгүүлчдийн өгүүлэл нийтлэлийн нөлөөгөөр монголын хөдөлмөрчид байгаль орчны асуудлаар олон нийтийн хэлэлцүүлэг хийхийг шаардаж, гарын үсэг зурсан өргөх бичиг, захидал, хүсэлтийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, намын байгууллага руу ирүүлэх болов. Тухайлбал Нийслэлийн ажилчин Дарь “Үнэн” сонинд ирүүлсэн захидалдаа “Би өнөөдөр “Утга зохиол, урлаг” сонинд Зөвлөлтийн ард түмэн Байгаль нуураа хэрхэн хайрлаж, аварч чадаж байгаа тухай материал уншаад, санаа зовж явдаг асуудлынхаа талаар танай редакцияд захидал бичихээр шийдлээ. Манай оронд Хөвсгөл нуур шиг тийм сайхан үзэсгэлэнт том нуур, Хөвсгөлийн тайга шиг тийм том хүчилтөрөгчийн үйлдвэр байхгүйг хэн хүнгүй мэднэ. Байгаль нуурын эрэг дээр байгуулсан цаасны үйлдвэрийг зайлуулахын тулд Зөвлөлтийн ард түмэн тийм их тэмцэл хийсэн байхад бид яагаад Монгол орныхоо сувд эрдэнэ болсон Хөвсгөл нуурын эрэг дээр үргэлж дэлбэлэлт хийх фосфоритын завод байгуулна гээд санаа амар сууж болдог байна аа? Байгаль хамгаалах асуудал ийм хүчтэй яригдах болсон өнөө үед бид ингэх эрхгүй гэж бодож байна. Энэ талаар олон хүн ярьж байгаа боловч яагаад албан ёсоор ярьж бичихгүй байгаад гайхах юм. Хэрвээ фосфорын үйлдвэрийг Хөвсгөл нуурын эрэгт байгуулах юм бол хамгаалах ямар ч арга хэмжээ авсан бид эцсийн эцэст нуур ч үгүй, тайга ч үгүй болно гэдэг тодорхой. Нуур, тайга, сайхан байгалиа алдаж, үр ач нартаа үеийн үед зэмлэгдэх хэрэг хийснээс фосфорын үйлдвэргүй байвал яасан юм бэ та минь!” гэжээ (Балдорж, Далай ээж маань цаазын тавцанд 1987). Дарийн захидал нь Байгаль нуурыг хамгаалах зөвлөлтийн туршлагыг монголчууд шууд өөрсдийн Хөвсгөл нууран дээр буулгаж харж байсныг нотолгоо юм.

Мөн Сүхбаатар аймгаас ирүүлсэн өөр нэг захидалд “Хөвсгөл маань мөнх байж байг!” “Байгалийнхаа нөөц баялгийг нээж, түүнийг нь дагаад шинэ хот суурин, үйлдвэр сүндэрлэн босгож байгаа нь жирийн хэрэг боллоо. Үүний нэг нь Хөвсгөл нуурын эрэгт сүндэрлэн босох фосфоритын үйлдвэр юм. Гэтэл Хөвсгөл нуур манай орны хувьд юу болох тухай тайлбарлах нь илүү гэж бодлоо. Бид дээрх үйлдвэрийг барьж байгуулах болоогүй гэдгийг шууд хэлэх гэсэн юм. Учир нь тэр үйлдвэр эдийн засагт асар их ашиг өгөх боловч Хөвсгөл нуурт нөхөж болшгүй гай тарих болно. Энэ үйлдвэр зуу, хоёр зуун жил ажиллаж ч болно. Гэтэл Хөвсгөл нуур мөнх байх ёстой. Мөнх байх байхдаа унаган төрхөөрөө, цэвэр тунгалаг байх ёстой. “Бид унаган байгалиа өмнөх үеэсээ өвлөж аваагүй, харин хойч үедээ унаган төрхөөр нь эргүүлэн өгөхөөр зээлдэж авсан юм” гэсэн нэгэн мэргэн үгийг санахгүй байж болно гэж үү? Мэдээж уг үйлдвэрийг барих хүмүүс зураг, төсөл хийсэн газар Хөвсгөл нуурыг “тэгж, ингэж хамгаална”, “гийм, ийм арга хэмжээ авна” гэж хэлэх ярих л байх. Түүнд үнэмших эрх бидний үед байна уу? Байгаль нуурын эрэг дэх целлюлоз-цаасны комбинатынхан В.Распутинд юу юу гэж ярьж тайлбарлаж байсныг сонсоогүй, мэдээгүй, дуулаагүй байх учиргүй. Фосфорит нь хэдийгээр бордоо болдог ч гэсэн химийн идэвхтэй хорт бодис шүү дээ. ЗХУ-д 20 гаруй жилийн өмнө алдсан алдаагаа засах гэж хэчнээн их ажил болж байгааг бид бүхэн харж байна. Одоо чинь үйлдвэрийн яндангаар олгойдох хар утаа хүнд үйлдвэрийн бэлгэ тэмдэг болж байсан 30, 40-өөд он биш шүү дээ. Тэгээд ч алийн болгон Хөвсгөл нуураар шатахуун тээж, Хөвсгөл нуурт ноос угаасан угаадсаа асгах хийх юм бэ? Бид Хөвсгөл нуурын тухай бичлээ. Бид тэр сайхан нуураа хараа ч үгүй өөр нутгийн (Сүхбаатар аймгийн) хүмүүс шүү” гэжээ (Балдорж, Далай ээж маань цаазын тавцанд 1987). Мөн Дорнод аймгийн тээврийг удирдах газрын техник, механикч Элдэв-Очир, Улсыг батлан хамгаалахад туслах нийгэмлэгийн аймгийн зөвлөлийн ажилтан, инженер механик Б.Пүрэвдорж “Сүүлийн үед хэвлэлд ажил хэрэгт нэмэр болох, зарим үед замыг нь заагаад шахам өгсөн санал бодол эргэцүүлэл их гардаг боллоо. Гэвч холбогдох газрууд үүнийг мэдсэн ч мэдээгүй юм шиг өнгөрөөж, сайжруулж, өөрчилж байгаа зүйлгүй хуучин хивэндээ зууралдсаар байх болсныг нам, засгийн төв хэвлэл анхаардаг биз дээ” (Балдорж, Далай ээж маань цаазын тавцанд 1987). Ц.Балдоржийн өгүүлэл нийтлэгдэхийн өмнө Улаанбаатар, Дорнод, Сүхбаатар аймгийн хөдөлмөрчдөөс “Үнэн” сонинд ирсэн захидлууд нь “Хөвсгөлийн асуудал”-ыг дэлгэрэнгүй сөхөж тавих нийгмийн хэрэгцээ байсныг харуулна.

5. Хөвсгөлийн фосфоритын төсөл.

Наяад оны эхэнд монголд социалист бүтээн байгуулалт ид хурдацтай хөгжиж байв. Уул уурхай дагасан томоохон хотууд ЗХУ болон Эдийн засгийн харилцан туслалцах зөвлөлийн (ЭЗХТЗ) тусламжтай байгуулагдаж өмнө хүнгүй зэлүүд байсан газарт Эрдэнэт зэрэг шинэ хотууд сүндэрлэн босож байв. ЗХУ болон ЭЗХТЗ-ийн хамтын ажиллагааны хүрээнд геологи, хайгуулын ажлыг эрчимтэй хийж, шинэ уурхай, үйлдвэр, хотыг байгуулах төслүүд ид яригдаж байв. Монгол оронд фосфоритын хоёр том орд Хөвсгөл аймагт Хөвсгөл нуурын ойролцоо байдаг. Хөвсгөлийн фосфоритын сав газар нь уртаашаа 300 км, дунд хэсэг дэх хамгийн өргөн газраа 20-30 мянган км квадрат талбайтай дэлхийд томоохонд тооцогдох орд газар. Уг сав газраас Бүрэнхаан болон Хөвсгөлийн ордууд нь нөөцөөрөө хамгийн томд орно (Мавлет, Хөдөлмөрөөр жигүүрлэсэн он жилүүд 2008, 53). Зөвлөлийн геологичид бүр 1960-аад оны дунд үеэс Бүрэнхаан, Хөвсгөлийн орд газрыг судалж эхэлжээ (Балдорж, "Далай ээжийг" цаазлахаар зэхэж байна 1989). Далаад онуудад Монголын талаас уг ордыг ашиглах талаар удаа дараа ярьж байсан боловч социалист системийн орнуудаас уг төслийг сонирхож хөрөнгө оруулагч олж чадахгүй байв. Сайд нарын зөвлөлийн дарга байсан Д.Содном энэ тухай “Уг нь бид фосфоритын ордоо ашиглахад тусламж авъя гэж ЭЗХТЗ гэх социалист улсуудын олон улсын байгууллагын шугамаар олон удаа санал тавьж байсан боловч шийдэгддэггүй байсан. Нэг удаа ЗХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Косыгин гуайд танилцуулахад дэмжлэг авч, геологи хайгуулын ажил зохиогдож, техник эдийн засгийн үндэслэл нь богино хугацаанд боловсрогдсон” (Содном 2003, 91) гэжээ. Ингээд хоёр орны хамтын ажиллагааны төлөвлөгөөнд орж Бүрэнхаанд 1981-1982 онд геологийн эрэл үнэлгээний, 1982-1983 онд урьдчилсан үнэлгээний, 1983, 1984 онуудад нарийвчилсан хайгуулын ажлуудыг хийж гүйцэтгэжээ (Мавлет, Хөдөлмөрөөр жигүүрлэсэн он жилүүд 2008, 53). Зөвлөлтийн талын хөрөнгө оруулалтаар хийгдэв. Гэвч дээрх тооцоогоор уг төсөл ашигтай эсэх эргэлзээтэй байв. Д.Содном энэ тухай “Гэтэл түүгээр

эдийн засгийн үр ашигтай байх нь батлагдаагүй учраас манайх ашиглая гэж байсан саналаасаа ухрахад хүрээд байсан юм. Тэр үед дэлхийн зах зээлд байсан фосфорын бордооны үнээс манай бордооны өртөг илүү гарахаар байсан юм” (Содном 2003, 91) гэжээ. Ингээд төсөл зогсонги байдалд ороод байв. Гэтэл 1983 оноос уг төслийг албан ёсоор ашиглах санал зөвлөлтийн талаас ирэх болов. Д.Содном “Засгийн газар хоорондын комиссын Зөвлөлтийн талын өндөр албан тушаалтан 1983 онд Хөвсгөлийн фосфоритын ордод ашиглалт явуулахад монголын тал сонирхож байна гэсэн албан ёсны санал ирүүл гэсэн шаардлага миний нэр дээр ирүүллээ. Би уг ордод ашиглалт явуулахыг зөвхөн эдийн засгийн өндөр ашигтай байх нөхцөлд монголын тал зөвшөөрөх болно гэсэн хариу цахилгаан төлөвлөөд Цэдэнбал даргад очиж танилцууллаа. Дарга тэр цахилгааны төслийг үзээд, чиний санал зөв, ийм хариу өгөх хэрэгтэй” гэж хэлжээ (Содном 2003, 92). Бүр жараад оноос л уг төслийг эдийн засгийн хувьд үйлдвэрлэлийн ач холбогдлоор сайнгүй гэж дүгнэлтийг хийж байсан ч (Балдорж, "Далай ээжийг" цаазлахаар зэхэж байна 1989) Монголын талд ч гэсэн уг ордыг ашиглах сонирхол байв.

1984 онд фосфорын баяжигдах чанарыг тодорхойлох, дээж авах зорилгоор Геологи уул уурхайн үйлдвэрийн Яам Налайхын уурхайн ахмад уурхайчин Жаргайгаар ахлуулсан бригадыг Мөрөнгийн зураглалын экспедицийн дарга Гүрлхаажав, геологич Далелхаан нар удирдлагад ажиллуулж, 100 м штольн нэвтэрч амжилттай дээж авч чаджээ. Уг дээж дээр үндэслэн Зөвлөлт Холбоот улсын “Госгорхимпроект” институт боловсруулж, ЗХУ-н ашигт малтмалын нөөцийг комиссын 1984 оны 8-р сарын 16-ны хуралдаанаар баталжээ (Мавлет, Хөдөлмөрөөр жигүүрлэсэн он жилүүд 2008, 54). Улмаар Зөвлөлтийн Хөвсгөлийн геологийн ерөнхий экспедиц 1983-1987 оны хооронд фосфорын Бүрэнхааны ордны судалгааны ажлыг хийж дуусгаад ил аргаар ашиглах Бүрэнхааны орд дээр түшиглэсэн уулыг баяжуулах үйлдвэр барих төслийг боловсруулжээ. Уг үйлдвэр нь бүрэн хүчин чадлаараа ажиллахад жилд 12 сая тонн фосфоритын хүдэр боловсруулна гэж тооцвол 40 жилийн нөөцтэй, нөөцийн ихэнх хэсэг нь нуураас 100 гаруй км-ын зайтай боловч багагүй хэсэг нь Хөвсгөл нуурын эрэгт 2.5-5 км зурвас газарт байгаа гэжээ (Балдорж, Далай ээж маань цаазын тавцанд 1987). Улмаар “Бүрэнхааны ордыг эзэмших асуудлаар монгол, зөвлөлтийн экспертийн ажлын групп 1986 оны 10-р сард хэлэлцээ хийж, үйлдсэн “Санамж бичигт” фосфоритын хүдэр олборлох, баяжуулах үйлдвэрийг БНМАУ-д байгуулж, харин бордооны үйлдвэрлэлийг ЗХУ-д зохион байгуулахаар тохиролцсон байна (Жасрай 1988).

Улсын төлөвлөгөөний комисс, Шинжлэх ухааны академийн Эдийн засгийн хүрээлэн МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны тусгай тогтоолд заасан дээрх чиглэлийг баримтлан үйлдвэрлэх хүчний 2000 он хүртэлх хөгжил, байршлын ерөнхий схемийг 1984 онд боловсруулжээ (Намжим, БНМАУ-ын үйлдвэрлэх хүчин, эдийн засгийн асуудал 1987, 6). “БНМАУ-ын үйлдвэрлэх хүчний хөгжил, байршлын 2000 он хүртэлх Ерөнхий схем”-д Хөвсгөлийн фосфорын ордыг ашиглахыг Монгол орны эдийн засгийн потенциалыг нэмэх хамгийн гол эх үүсвэрийн нэг, уулын баяжуулах үйлдвэрийн хүч чадлыг жилд 12 сая тонн хүдэр боловсруулахаар заажээ. Уг төслийг боловсруулж байх үед түүхий эдийн үнэ сайнгүй байсан ураас тухайн үедээ төсөл нь эдийн засгийн хувьд огт ашиггүй болж байсан, үүнийг “фосфоритын баяжмалыг дэлхийн зах зээлийн үнээс 3.3 дахин, бордоо, гэжээлийн фосфоритынхыг 4,5-6,1 дахин өндөр үнээр зарах нөхцөлд л үйлдвэрлэлийн хувьд 5 хувийн ашигтай үйл ажиллагаа хангагдаж чадна” гэжээ (Балдорж, "Далай ээжийг" цаазлахаар зэхэж байна 1989). Дээрх баримтуудаас харахад боловсрогдсон техник эдийн засгийн үндэслэл, дэлхийн зах зээл дэх фосфорын үнийг харьцуулан тооцоход Хөвсгөлийн төсөл нь анхнаасаа эдийн засгийн үр өгөөжтэй нь батлагдахгүй байсан ч ажил нь үргэлжилсээр л байжээ.

Геологийн судалгаа, үнэлгээний ажил нь 1981-1987 он хүртэл бараг зургаан жил үргэлжилж олон янзын тэсэлгээ хийжээ. Энэ явцад байгаль орчин ихээр сүйдэж эвдэрч гэмтэв. Ганцхан жишээ дурдахад Хөвсгөлийн Онгилог Хэрсэвтэй Хясаа хавийн нутаг геологийн хайгуул шинжилгээний ажлын тэсэлгээнд өртөж олон төрлийн зам, томоохон нүх шуудуунууд үүсжээ. Зөвлөлтийн экспедицийн Хөвсгөлийн геологи хайгуулын ангийн дарга Людофун Ф.Н. ангийн орлогч дарга Б. Садулли нар 1987 оны 11-р сарын 18-ны өдөр гурван жилийн турш өөрсдийн тэсэлгээ хийсэн газрыг цэвэрлэж, эргэж булж техникийн нөхөн сэргээлт хийж Хөвсгөл нуурын хамгаалалтын захиргааны даргаа Ө.Нэргүй, ахлах мэргэжилтэн Д.Энхтүвшин, мэргэжилтэн Д.Пүрэвдаш нарт хүлээлгэн өгсөн

байна. Гэвч 159000 метр куб суваг шуудууг техникийн бус гараараа хийх учраас хэвээрээ үлдсэн, малчид нутаг устайгаа хэлмэгдэхэд хүрчээ (сурвалжлагч 1990).

1986 онд Хөвсгөлийн тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааг хориод хүний орон тоотой байгуулсан⁵³, Хөвсгөл нуурыг хамгаалах үүрэг нь “Ой модны аж үйлдвэрийн яам, түүний нэгэн хэлтэст харьяалагдаж байв (Балдорж, Далай ээж маань цаазын тавцанд 1987)⁵⁴.”

1987 оны байдлаар Хөвсгөл нуурыг бохирдуулж байгаа хүчин зүйлсийг сэтгүүлч Ц.Балдорж гурван шалтгаанаар дурдсан үүнд нэгд, бүр жараад оноос Зөвлөлт Холбоот улсад ашиглахаа больсон 300 тонн нефть тээврийн “Ургац” чиргүүлийг Хөвсгөл далайд одоо хүртэл ашиглаж байгаа нь далайд нефтийг асгах эрсдэлтэй байгаа, хоёрт, Хөвсгөл нуурт живсэн тээврийн хэрэгсэл, үүнд 1986 онд 42 метр урттай, 18 метр өндөр, 300 тонн жинтэй Сүхбаатар хөлөг онгоц живсэн, гуравт, Хөвсгөл нуурын хаяаны “Ноос угаах үйлдвэрийн бохир усны цооног”, дөрөвт хууль бус аргаар мөс дэлбэлэн загачлах зэрэг болно (Балдорж, Далай ээж маань цаазын тавцанд 1987, 70-71).

6. “Үнэн”-ий “өөрчлөн байгуулалт” ба сэтгүүлчдийн Хөвсгөл хөдөлгөөн.

1984 онд “Үнэн” сонины эрхлэгч Л.Түдэв⁵⁵ томилогдов. Тэрээр МАХН-ын Төв Хорооны гишүүнээр 1972 оноос хойш тасралтгүй сонгогдсон, 1975-1984 он хүртэл МХЗЭ-ийн нэгдүгээр нарийн бичгийн дарга хүртэл дэвшин ажилласан, тэр ондоо докторын зэрэг хамгаалсан, Монголын Сэтгүүлчдийн Холбооны тэргүүний ажлыг давхар хавсарсан нөлөө бүхий, хүлээн зөвшөөрөгдсөн лидер байв (Sanders 1996, 204). Дашрамд дурдахад Л.Түдэвийн “Таацын цагаан нуурыг аврагтун” (асуудал дэвшүүлсэн өгүүлэл) гэсэн өгүүллийг 1984 онд “Залуучуудын үнэн” сонины тэргүүн нүүрт хэвлэгджээ (Түдэв, 1990, хууд. 10). Өгүүллийн зорилго нь Өвөрхангай аймгийн Баруунбаян-Улаан сумын нутаг Говьд оршдог нуур ширгэсэн асуудлыг анхаарч үзэж уг нуурын усыг сэргээхэд холбогдох байгууллагын үйл ажиллагааг уялдуулахын чухлыг дурджээ. Уг өгүүлэл нь байгаль орчныг хамгаалах андагчдын нэг төдийгүй уг асуудлаар хэлэлцүүлэг хийж нам төрийн байгууллага тодорхой үйл ажиллагаа явуулснаараа онцлог юм. Мөн түүний “Шинэ хөдөө” сонинд 1985 онд “Цэнгэг ус” хэмээх асуудал дэвшүүлсэн нийтлэл нь мөн цэнгэг ус, усны нөөх, хэрэгцээний усны асуудлыг хөндсөн бөгөөд усыг үр ашигтай хэрэглэх, мөн усан сан байгуулах, усыг цэнгэгжүүлэх зэрэг тулгамдсан асуудлыг дэвшүүлжээ (Л. Түдэв 1990, 10-15).

Түүхч М.Энхбаатарын ажигласнаар “Үнэн” сонин 1987 оны эхээр 26 дахь дугаартаа “Өөрчлөн байгуулалт аугаа их хувьсгалт үйл явц” гэсэн редакцын өгүүлэл нийтлэв. Уг өгүүлэлд ЗХУКН-ын Төв Хорооны бүгд хурлаас дэвшүүлсэн шинэ зорилтыг дэлгэрэнгүй тайлбарласан юм. “Үнэн” сонин дараагийн дугааруудаас “Өөрчлөн байгуулалт аугаа их хувьсгалт үйл явц” гэсэн байнгын булан нээж “Намын онолын үйл ажиллагааны шинэ хандлага” (№27), “Социалист ардчиллыг шинэ шатанд дэвшүүлж байна” (№29), Лениний намын үлгэр дуурайл (№27) зэрэг редакцын өгүүлэл, улс төрч, эрдэмтэн, судлаачдын сурталчилгааны өгүүлэл, тайлбарыг цувруулан нийтэлж байв” (Болдбаатар, Ж ба Морозова, Ирина 2013, 78). Бусад сонинууд ч гэсэн үүнийг дагаж байв. Тухайлбал 1987 оны 1-р сараас Утга зохиол урлаг сонинд “Өөрчлөн байгуулалт хувьсгалт үйл явц” хэмээх булан нээгдсэн⁵⁶, сард нэг удаа материал нийтэлж байгааг чамлалтай гэж Намын Төв хорооноос сүүлд үнэлсэн нь бий. Ингэж “Үнэн” сонин МАХН-ын ЕНБД Батмөнх “өөрчлөн байгуулалт” намын чиг шугам гэж албан ёсоор зарлахаас хагас жилийн өмнө, МАХН-ын V бүгд хурлаас бараг хоёр жилийн өмнө өөрсдийн уншигчдадаа “өөрчлөн байгуулалт”-ыг албан ёсоор зарласан байв.

⁵³ Ж.Оюумаа: Монголчууд наадмаар Хөвсгөл далайг “гамшиг” болгодог (shuud.mn)

⁵⁴ Ж.Төмөрсүх: Байгаль хамгаалагчид бидний сэтгэлд эх орноо хамгаалах зорилго үргэлж хадаатай байдаг (olloo.mn)

⁵⁵ Л.Түдэв нь 1935 онд Говь-Алтай аймгийн Наран суманд төрсөн, 1942-1950 Говь-Алтай аймгийн дунд сургууль, 1950-1953 онд Улаанбаатарт Багш нарыг бэлтгэх сургууль, 1953-1956 онд УБДС, 1964-1967 онд Москвад ЗХУКН-ын Төв хорооны дэргэдэх Нийгмийн ухааны академийг дүүргэж дэд эрдэмтэний зэрэг хамгаалсан. 1956-1959 онд Говь-Алтай аймгийн арван жилийн сургуульд багш, 1967 оноос МАХН-ын Төв хорооны үзэл суртлын хэлтэст, 1968 оноос Монголын зохиолчдын эвлэлийн хорооны орлогч даргаар, 1978-1984 он хүртэл 1984 оноос “Үнэн” сонины эрхлэгчээр томилогджээ.

⁵⁶ (МАХН-ын архив Хөмрөгний дугаар 4, Дансны дугаар 37 ХН дугаар 30 он 1987 144-р хуудас)

Үнэн сонины өөрчлөн байгуулалт нь гурван төрлийн үйл ажиллагаанаас бүрдэнэ. Доор дурдсан загвар байгаль орчныг хамгаалах сэдвийг маш сайн боловсруулж нийгмийг өөрчлөхөд маш сайн үр дүнг гаргасан юм.

Нэгд, ЗХУ-д өрнөж байгаа өөрчлөн байгуулалтай холбоотой дарга нарын хэлсэн үг, илтгэл, ярилцлагыг цаг тухайд нь бүрэн эхээр нэгдүгээр нүүрэндээ нийтэлж байв. Бусад хэвлэлүүд ч гэсэн зөвлөлтийн “Правда”, “Известия” зэрэг сонинуудад нийтлэгдсэн Байгалийг хамгаалах хөдөлгөөний зохиолч, эрдэмтдийн өгүүлэл, нийтлэл, ярилцлагуудыг орчуулан хэвлэж байв. Зөвлөлтийн дагуул улсын хувьд монголын төлөвлөгөө аж үйлдвэржүүлэлтийн явц нь зөвлөлтийн бодлогын хуулбар, нэг хэсэг нь болж байсны хувьд тухайн өгүүлэл, нийтлэлүүд нь шууд л монголын нөхцөл байдалтай хэрхэн холбогдож байгаа нь иргэдэд маш тодорхой байв.

Хоёрт, “ил тод байдал”-ын тусгалаар наяд оныг хүртэл нуугдмал байсан олон чухал асуудлыг албан ёсоор хөндөж сэтгүүлч, судлаач эрдэмтэд, мэргэжилтнүүдэд албан ёсоор захиалга өгөн нийтлэл, ярилцлагуудыг хэвлэж байв. Байгаль орчны сэдвээр ус, мод, хөрс, улаан номд орсон амьтан гэсэн сэдвүүдээр тэргүүн өгүүлэл нийтлэл, ярилцлага захиалан бичүүлж байв. Тухайлбал “Үнэн” сонины 1987 оны дугаар 47-д Г.Жамцын “Эх орны ногоон хүрэм сэглэгдэж байна”, дугаар 233-д Ц.Балдоржийн “Далай ээж цаазын тавцанд”, дугаар 236-д Ш.Цэен-Ойдовын “Зарлигаар дархалсан ууланд зэрлэгээр халдах эрх олгожээ” зэрэг өгүүлэл нийтлэгдсэн байна.

Наяас ерэн он хүртэлх хугацаанд “Үнэн” сонинд хэвлэгдсэн экологийн сэдвийг судлаач Ч.Чойсамба судалж үзжээ. Судалгаагаар “27.6 хувь нь мод, нөөцийн хомсдол, 22.5 хувь нь байгалийн шинжлэл, 13.8 хувь нь ус усны бохирдол, 13.6 хувь нь ан амьтан, 9 хувь нь дархан цаазат газар, 7.2 хувь нь цөлжилт, 2.9 хувь нь бэлчээрийн даац, бэлчээрийн даац, хөрсний бохирдол, 1.2 хувь нь алт, ашигт малтмал, 1.4 хувь нь байгаль орчныг хамгаалах, 0.8 хувь нь хог хаягдал, агаарын бохирдол зэргийг дурджээ (Чойсамба 2011, 35).

Гуравт, сонины асуудал хөндсөн нийтлэл нь хөдөлмөрчдийг мэдээллээр хангаж улмаар тэднээс ирэх хариу санал сэтгэгдэл, өргөдөл, гомдол, хүсэлтийг нь албан ёсоор сониндоо хүлээн авч хариу өгч тусдаа булан болгон нийтэлж уншигчдын өөр хоорондоо санал бодлоо солилцох индэр болгож идэвхжүүлж байв. Ингэж “ил тод байдал” нь байгаль орчны бохирдол, хамгааллын асуудлыг шинээр сөхөн тавихад хүргэв. 1987 оны 6 сар гэхэд НТХ-ноос “ил тод байх зарчмыг удирдлага болгон НТХ-ны Ерөнхий хэлтэс “Үнэн” сонинд “Хөдөлмөрчдийн захидал-нам олон түмний холбоо” гэсэн тусгай нүүр гаргаж сурталчилж эхэлжээ⁵⁷. Чухам ингэж “Үнэн” сонин манлайлан наяд оны дунд үеэс байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах талаар олон санал санаачилгыг гаргаж манлайлж олон нийтийг идэвхжүүлж ирсэн байна (Цэрэннадмид 1991, 3). (Баасансүрэн 2009). Гадаад ба дотоод “уярал”-д идэвхэжсэн иргэд сонины шуугиант нийтлэлийн мөрөөр олон захидлыг ирүүлж байв. 1987 оны эхний улирлын байдлаар “Үнэн” сонинд ирсэн зуун захидал мэдээллийг нэгтгэн дүгнэж үзэхэд 75 хувь нь эрэгтэйчүүд, 41 хувь нь өндөр настан, 16 хувь нь гучаас тавь хүртэл насныхан, 12 хувь нь гуч хүртэл насны хүмүүс, үлдсэн хүмүүсийн нас тодорхойгүй байжээ (Чойжилжав 1987). Үүнээс харахад эрэгтэйчүүд, өндөр настнууд илүү идэвхтэй захидал, мэдээлэл бичиж байжээ. 1989 оны 5-р сарын 19-ны өдөр Эрдэнэт хотод болсон “Үзэл суртлын ажилтны бүсийн зөвлөгөөн”-д Хөвсгөл аймгийн Тариалан сумын намын хорооны нарийн бичгийн дарга Л.Санжсүрэн “Нам, засгийн “Үнэн” сонин болон төвийн бусад хэвлэлүүдэд хурц асуудлууд ихээхэн хөндөгдөж хөдөлмөрчдийн талархлыг хүлээж байна” гэсэн⁵⁸ бол Хөвсгөл аймгийн намын хорооны нарийн бичгийн дарга Н.Чимэддорж “Хөдөөгийн иргэд ч олон улсын байдал зэргийг илүүтэй сонирхдог болжээ” гэжээ⁵⁹. 1987 онд “ил тод байдал” хүчтэй эхэлж байсан ч ХУЗХГ татан буугдаагүй, “өөрчлөн байгуулалт” монголд эхлээгүй, тиймээс нам, засгийн зүгээс хориотой сэдвийг хөндөх, уг сэдвээр нийтлэл, ярилцлага хэвлэх боломж огт байгаагүй үе. Гагцхүү Зөвлөлтийн туршлага дээр үндэслэсэн, нам, засгаас “тодорхой хэмжээгээр зөвшөөрсөн” мөн олон нийтийн анхаарлыг татсан тийм асуудлуудыг “тодорхой хил хязгаар”-ын дотор “шуугиан” тарихыг хүлээн зөвшөөрч байв. Зөвлөлт дэглэмд олон

⁵⁷ (МАХН-ын архив Хөмрөгний дугаар 4, Дансны дугаар 37 ХН дугаар 40 он 1987 111-р хуудас)

⁵⁸ (МАХН-ын архив Хөмрөгний дугаар 4, Дансны дугаар 37 ХН дугаар 297 он 1989 67-р хуудас)

⁵⁹ (МАХН-ын архив Хөмрөгний дугаар 4, Дансны дугаар 37 ХН дугаар 297 он 1989 38-р хуудас)

нийтийг идэвхжүүлж дайчилгаанд оруулахдаа коммунист намын үзэл суртлын хэлтэс, сонины редакцаас холбогдох хүмүүст албан ёсоор захиалга өгч хэвлүүлдэг туршлага ноёрхож байсан бөгөөд ийм “захиалга”-аас гадуурх өгүүлэл, захидал бол тухайн сонины сэтгүүлчийн цензур, эрхлэгч нарын цензур, ХУЗХГ-ын гурван давхар цензурийг давах эрх байгаагүй. Чухам ийм нөхцөлд уг сэдвийг хөндсөн гэдгийг онцлох хэрэгтэй. Дурдсан шалтгааны улмаас “Үнэн” сонины эрхлэгч Л.Түдэв уг сэдвээр нийтлэл бичих даалгаврыг Ц.Балдоржид өгчээ. Л.Түдэв энэ тухай “хорь гаруй жилийн тэртээ” ““Үнэн” сонинд эл өгүүллийг гарч байх үед дээрд дурдсан шиг бид нэг багт ажиллаж, залуучуудад нийгмийн амьдралд үүсээд буй, үүсэх магадлалтай сэдвээр даацтайхан зүйл бичих санал хэлж, зарим чадалтай авьяастайд нь бүр даалгавар өгч захиргаадан “Үнэн” сонинд гаргаж явснаа энэ цөөн мөрийг тэрлэх үед санаж байна” гэжээ (Балдорж, "Далай ээж" маань цаазын тавцанд 2008).

Улмаар 1987 оны 9-р сарын 29-нд (233-р дугаарт) “Далай ээж маань цаазын тавцанд” хэмээх өгүүллийг “Үнэн” сонины сурвалжлагч Ц.Балдорж⁶⁰ хэвлэсэн. Анхны нэр нь өөр байсан бөгөөд яг хэвлэхийн өмнө Л.Түдэв эрхлэгч нэрийг нь өөрчилж хэвлэжээ (Балдорж, "Далай ээж" маань цаазын тавцанд 2008, 7). Ц.Балдоржийн өгүүлэл нь долоон хэсгээс бүрдэнэ, эхний Хөвсгөл нуурыг монголчууд эртнээс шүтэж ирсэн уламжлалын тухай, мөн Байгаль далайтай хүйн холбоотой тухай, Хөвсгөл нуураар нефть тээвэрлэж байгаа усан онгоцны чиргүүл нь стандартын шаардлага хангахгүй болж нуурыг бохирдуулах эрсдэлтэй байгаа тухай өгүүлжээ. Мөн нийтлэлд Хөвсгөл нуурыг хамгаалах захиргааг шүүмжилсэн, нууртай холбоотой ажиллаж байгаа байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах, нуурыг хамгаалах талаар бодитой ажлууд хийх шаардлагатай байгааг онцолжээ. Хөвсгөл нуурын ойр орчмоос фосфорын ордыг нээн илрүүлж ухаж ашиглах гэж байгаа нь нууртай холбоотой хоёрдох буюу гол аюул гэж үзсэн. Учир нь ил аргаар тэсэлгээ хийхэд дэгдэх химийн найрлагатай тоос Хөвсгөл нуурыг бохирдуулна, фосфорит ба хөрс, усыг тусгаарлагч шохойн чулуу нуурыг бохирдуулах гол элемент болно гэжээ. Тэрээр өөрийн саналыг үндэслэхдээ зөвлөлтийн зохиолч Распутины нийтлэлээс ишлэж⁶¹ авсан ба Байгаль далайг хамгаалах Распутины хөдөлгөөнийг загвар болгон дуурайв. Тэрээр “Зөвлөлтийн хүмүүс шиг байгаль орчноо хамгаалах асуудалд сонор соргог хандахад бид суралцах болжээ” гээд “Ганц жишээ хэлэхэд Зөвлөлт, Японы зохиолчид хамтран “Байгалын хөдөлгөөнийг” саяхан санаачлан зохион байгууллаа. Уг хөдөлгөөнийг үндэслэгчид нь гаргасан мэдэгдэлдээ цэвэр уст нуур болон ундааны усны бүх эх үүсвэр нь дэлхийн улс түмнүүдийн баялаг бөгөөд тэдгээрийг зүй зохистой ашиглах нь нийт хүн төрөлхтний үйл хэрэг” гээд зохиолчдын жил бүр зохиох “Байгалийн хөдөлгөөн” уламжлалт уулзалтад орон орны зохиолчдыг оролцохыг урилаа” гээд улмаар ““Байгалийн хөдөлгөөнийг” Хөвсгөлтэй холбож, ойрын үед Хөвсгөл нуурын хөвөөнд уулзалт хийгүүштэй” гэж уриалжээ. Товчоор хэлбэл Хөвсгөлийг хамгаалах хөдөлгөөнийг байгуулж, эсэргүүцэл зарлахыг тэрээр уриалжээ. Ингэж Ц.Балдорж “Үнэн” сонинд Хөвсгөл далай ойролцоо үйлдвэр байгуулах намын шийдвэрийг эсэргүүцэж байгаа гэдгээ мэдэгдээд Байгалийн хөдөлгөөний нэг хэсэг болгож Хөвсгөлийн хөдөлгөөн үүсгэхийг уриалсан юм.

Өгүүлэл тун ч гайхамшигтай нөлөөг үзүүлэв. Өгүүллийг дэмжсэн захидал “Үнэн” сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгсэлд олноороо ирэв. Л.Түдэв энэ тухай “Тэр өгүүлэл сонинд гарсны дараа уншигч нараас талархсан дэмжсэн олон захидал сонинд ирж, заримыг тоймлон, бас заримыг нь сониндоо бүрэн эхээр нийтэлж” байв гэжээ (Балдорж, "Далай ээж" маань цаазын тавцанд 2008, 7). Өгүүллийн мөрөөр Нийслэл дэх геологийн дөрвөн байгууллагын 126 хүний гарын үсэгтэй нэгэн иржээ. Захианд “Хөвсгөл нуураас зуу гаруй км зайд оршдог Бүрэнханы фосфоритын ордыг ашиглахад нуурт үзүүлэх хор нөлөө байхгүй гэж зарим хүмүүс үзэж байгаа нь төөрөгдөл юм. Тэр ордын 600 метр хүртэлх гүний хүдрийг олборлохын тулд ойролцоогоор дөрвөн хавтгай дөрвөлжин км талбайтай хорь гаруй карьер ухахад нуур орчны байгаль юу болох нь тодорхой” гэжээ (Балдорж,

⁶⁰ Ц.Балдорж нь 1953 онд Говь-Алтай аймгийн Шарга суманд төрсөн, 1970 онд Төв аймгийн Жаргалантын арван жилийн дунд сургууль, 1977 онд ЗХУ-ын Эрхүү хотын Улсын их сургуулийн сэтгүүлчийн анги, 1977-1984 онд “Үнэн” сонинд сурвалжлагч, 1984-1987 онд ЗХУ-ын Москва хотын Нийгмийн ухааны академийн аспирантурыг дүүргэсэн. 1987-1990 он хүртэл “Үнэн” сурвалжлагчаар ажиллаж байжээ.

⁶¹ Дашрамд дурдахад энэ ишлэл нь ихээхэн том хэмжээтэй бөгөөд бараг нийтлэлийн дөрөвний нэг болж байна.

Хүйн холбоотой Хөвсгөл, байгал хоёр 1989). Уул уурхайтай шууд холбоотой геологийн дөрвөн байгууллагын бүх ажилчид эв нэгдэлтэйгээр гарын үсгээ зурж эсэргүүцэл илэрхийлсэн гэж бодохоор тухайн үеийн хүмүүсийн сэтгэл хөдлөл, мэдрэмж хэр хурц байсныг тод харуулна. Т.Баасансүрэн энэ үеийн тухай “Эдгээр шүүмжлэлт нийтлэлүүд монголын нийгмийн доргиож байсан билээ” гэж дүгнэжээ (Баасансүрэн 2009, 9).

1988 оны 7-р сарын 6-нд Монголын сэтгүүлчдийн холбооны санаачлагчаар БНМАУ, ЗСБНХУ-ын сэтгүүлчдийн холбоодын төлөөлөгчдийн “дугуй ширээний” уулзалт-ярилцлага Улаанбаатар хотод болов. Хуралд оролцогчид нь “Байгал нуурын сав газрын салшгүй хэсэг нь Хөвсгөл нуур” “дэлхийн цэнгэг усны 20 гаруй хувийг өөртөө агуулсан усан сан” учир “энэхүү нандин эрдэнэ үеийн үед хамтын хүчээр хайрлан хамгаалах” ёстой “зөвлөлт, японы зохиолчдын санаачилсан “Байгал нуурын хөдөлгөөний” дэмжих нь зүйтэй гэж үзэж байна” гэжээ. Улмаар Хөвсгөлийн фосфоритын ордыг олборлох, барилга байгууламж барихыг зогсоох хэрэгтэй гэсэн тунхаг гаргажээ (Үнэн, Байгал, Хөвсгөл нуурын байгалийн зохицлыг хамгаалах асуудлаар монгол, зөвлөлтийн сэтгүүлчдийн хийсэн дугуй ширээний уулзалтанд оролцогчдын уриалга 1988). Уулзалтын дараа монголын зохиолчид ЗХУ-ын Эрхүүд айлчилж хоёр орны хамтарсан зохиолчдын уулзалт 1988 оны 7-р сарын 6-нас долоо хоногийн турш үргэлжилжээ (Үнэн, Зөвлөлт, Монголын зохиолчдын уулзалт 1988). Ингэж монголын Хөвсгөл нуурыг хамгаалах хөдөлгөөн сэтгүүлч, зохиолчдын санаачлагчаар албан ёсоор байгуулагджээ.

Социалист нийгэмд “ХУЗХГ” нь хэвлэл мэдээллийг хэрэгслийг үзэл суртлын үүднээс хөндлөнгөөс хянадаг гол байгууллага. Тус байгууллагыг зөвлөл 1987 оны 1-р сард ЗХУ-д ХУЗХГ-ыг Горбачев татан буулгажээ (Beissinger 2002, 59). Харин монголд “ХУЗХГ”-ыг 1947 онд байгуулсан бөгөөд улмаар 1988 оны 7-р сарын 6-ны өдрийн МАХН-ын Төв Хорооны УТТ-ны 154 тоот тогтоолоор татан буулгаж 9-р сарын 1-нэс эхэлж дагаж мөрдөж эхэлжээ (Энхтүвшин 2013). Ингэж албан ёсоор хөндлөнгөөс хянадаг байгууллага үгүй болсноор монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл хөгжлийн дараагийн шат руу гарах боломжийг олж авахад тун ойртсон юм. Чухам тийм учраас 1988 оны сүүл, 1989 оны шүүмжлэлт нийтлэл, өгүүлэл, ярилцлагууд нь чухамдаа сэтгүүлч, редакцын үзэл санаагаар бүтээгдэж байв.

1989 оны 5-р сарын 24-нд МАХН-ын ТХ-ноос “Эрдэнэт хотод болсон үзэл суртлын ажилтны ээлжит зөвлөлгөөн”-д Хөвсгөл аймгийн Тариалан сумын намын хорооны нарийн бичгийн дарга Л.Санжсүрэн “Нам, засгийн болон төвийн бусад хэвлэлүүдэд хурц асуудлуудыг хөндөж, хөдөлмөрчдийн талархлыг хүлээж байна. Гэтэл үүнийг эсэргүүцэж, эргэлзсэн яриа ч гарч байна. Миний хувьд харин цааш үргэлжлүүлэх нь зүйтэй гэж бодогдох юм. Олон хурц асуудлыг, олон янзын үзэл бодлыг зэрэгцүүлж тавих нь зүйтэй. Эндээс л үнэн мөнийг олох учиртай гэв” гэж бичжээ. (Балдорж, Ц., Ногоя, Ё., Цэрэнжав, Д 1989).

Ингэж “Ил тод байдал”, “өөрчлөн байгуулалт” нь иргэдийг сэрээж Намын төв хороонд захидал ирүүлэх нь ихсэв. Иргэдийн санал бодол нь намаас зохион байгуулж байгаа хурал семинар дээр хүртэл үүнийг шууд асуух болов. Ц.Балдоржийн өгүүлэл гарсны дараахан 1987 онд 10-р сарын 5-ны НТХ-ны хэлтсийн зааварлагч Т.Етекбайгийн бичсэн “Ховд аймагт НУТС-ийн суртал нэвтрүүлэгчдийн семинар удирдаж, үзэл суртал хүмүүжлийн ажлын байдалтай танилцсан” тухай “Илтгэх хуудас”-д “Семинарын үеэр Хөвсгөлд фосфоритын үйлдвэр байгуулахад экологийн асуудлыг нь шийдвэрлэсэн үү?” гэж асуужээ⁶². Нэр бүхий хүмүүс АИХ-ын тэргүүлэгчдэд хандан байгаль орчин Хөвсгөлийн асуудлыг анхааралдаа авахыг хүссэн гарын үсэгтэй захидал ирүүлж байжээ⁶³.

1985 онд нийтдээ 1071 иргэн захидал НТХ-нд ирүүлж 540 хүн ирж уулзаж байсан бол 1986⁶⁴ онд энэ тоо захидлын тоо 1172 болж өссөн бөгөөд ирж уулзсан хүний тоо үл ялих багаар өсжээ. Улмаар

⁶² (МАХН-ын архив Хөмрөгний дугаар 4, Дансны дугаар 37 ХН дугаар 32 он 1987 78-79-р хуудас)

⁶³ (МАХН-ын архив Хөмрөгний дугаар 4, Дансны дугаар 37 ХН дугаар 23 он 1987 111-р хуудас).

⁶⁴ (МАХН-ын архив Хөмрөгний дугаар 4, Дансны дугаар 37 ХН дугаар 40 он 1987 16-р хуудас)

захидлын хэмжээ 1988 онд 1271 олж өсөж, 1989 онд 1379 болж өсжээ. Зарим захидлууд нь Хөвсгөлийн асуудал дээр хаягласан боловч “зөвлөлтийн эсрэг” бүр ноцтой сэдвүүдийг ч хөндөж байв. МАХН-ын Төв Хорооны Ерөнхий хэлтсийн дарга Я.Лосолсүрэн 1987 оны 11-р сарын 27-нд Сот 2-ын харуул Г.Лхагвасүрэнгийн 1987 оны 11-р сарын 10-ны өдөр Монголын радиогийн газар ирүүлсэн захидалтай холбогдуулан уулзжээ. Лхагвасүрэн бичихдээ “Манай улсын маань нэг хэсэг болох онгон сайхан үзэсгэлэнтэй Хөвсгөл нутаг өөрийнхөө эмгэнэлт хувь заяаг хүлээж байна” гэж бичжээ. НТХ-ноос Я.Лосолсүрэн энэ асуудлаар түүнтэй уулзаж тайлбар хэлэхдээ “НТХ-ноос сүүлийн жилүүдэд байгаль орчныг хамгаалах талаар дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлж байгаа та бүхэн мэдэж байгаа байх. Саяхан Богд уулын хамгаалалтын талаар УТТ хэлэлцээд, гэм буруутай зарим ажилтнуудад зохих арга хэмжээ авч, тогтоол гаргаж, хэвлэлд мэдээлсэн. Хөвсгөл нуурын талаар ч Намын Төв хороо тусгайлан авч хэлэлцсэн. Энэ үзэсгэлэнтэй нутгийг унаган төрхөөр нь байлгах явдал чухал байна” гэжээ. Түүний захидлыг Нэхмэлийн үйлдвэрийн ажилчдаас ирүүлсэн нэргүй захидалтай хамтатган танилцуулга боловсруулж Батмөнх даргад танилцуулав” гэжээ⁶⁵.

Өгүүлэл гарсны дараа Засгийн газар ба орон нутгийн удирдлагууд тодорхой ажлуудыг богино хугацаанд хийж гүйцэтгэв. Ердөө гурван сарын дараа буюу 1988 оны 1-р сард БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга, Улсын төлөвлөгөөний комиссын дарга П.Жасрай, Хөвсгөл аймгийн Ардын Депутатуудын хурлын Гүйцэтгэх захиргааны дарга У.Заяат нар “Далай ээж маань цаазын тавцанд” шүүмжлэлт нийтлэлийн мөрөөр авч хэрэгжүүлсэн хариуг “Үнэн” сонины 1988 оны 1-р сарын 14-ны өдөр дугаар арван хоёрт “Манай нийтлэлийн мөрөөр юу хийв?” гэсэн буланд нийтэлжээ. П.Жасрай хариундаа шатахуун тээврийн “Ургац” чиргүүл онгоцонд засвар хийхийг Тээврийн яаманд, цаашдаа нуураар нефтийн бүтээгдэхүүн тээвэрлэхийг зогсоох, Хатгалын ноос угаах үйлдвэрийг 1988 онд хааж, үйлдвэрийн барилга байгууламж, ажиллах хүчийг ашиглан оёдлын үйлдвэр зохион байгуулахыг Хөнгөн үйлдвэрийн яаманд” үүрэг болгов. Мөн “Ханх дах нуур судлалын станц, “Хөвсгөл нуурын хамгааллын захиргааны судалгаа шинжилгээний ажлыг уялдуулахыг Байгаль орчныг хамгаалах Яам, Дээд, тусгай дунд боловсролын улсын хороонд даалгажээ”. Улмаар хамгийн чухал хэсэг буюу фосфорын ордын талаарх байр сууриа илэрхийлэв. Үүнд уг ордыг монгол зөвлөлт хамтран ашиглах “Санамж бичиг” хүчинтэй байгааг дурдаад гагцхүү “техник эдийн засгийн үндэслэлд болон зураг төслийн бусад баримт бичигт байгаль, орчныг хамгаалахтай холбоотой арга хэмжээг зохих үндэслэл, тооцооны үндсэн дээр тодорхой авч үзэж тусгах үүрэг өгөгдсөн болно” гэжээ. Мөн академи, их сургууль, Байгаль орчны хамгаалах нийгэмлэг, геологийн институтийн эрдэмтдээс бүрдсэн мэргэжилтний групп томилж Бүрэнханы фосфоритын ордыг эзэмшвэл Хөвсгөл далайд хэрхэн нөлөө үзүүлэхийг тодорхойлох, эсрэг нөлөөллөөс хамгаалах арга хэмжээний талаар дүгнэлт гаргуулжээ (Жасрай 1988). Гэвч Бүрэнханы фосфоритын ордыг ашиглах төлөвлөгөө огт зогсоогүй гэдгийг утга уянгын халилгүй тодорхой илэрхийлсэн. Харин У.Заяат хариундаа “Далай ээжийг цаазлах үндсэн шалтгаан болсон шатахуун тээврийн “Ургац” чиргүүлийг тээвэрт ашиглахыг зогсоож, хөвөлтийн талбайгаас нуурын эрэг дээр гаргаж их засварт оруулав” гээд цааш нь Хөвсгөл нуурын орчмын газрыг хамгаалах байгаль хамгаалах төлөвлөгөөг боловсруулж мөрдүүлэх, хог хаягдлыг цэвэрлүүлэх, загас агнуурыг хориглох, эвдэрсэн хөрсийг сэргээх, мод тарих, Хөвсгөл нуурыг хамгааллын захиргааг мэргэжлийн хүмүүс ажиллуулах, машин тоног төхөөрөмжийг нэмж олгох, нуур хамгаалах, ой түймрээс сэргийлэх самбар байршуулах зэрэг ажлыг хийснийг дурджээ (Заяат 1988).

Ц.Балдоржийн араас Хөвсгөлийн сэдвээр олон зохиолч сэтгүүлч нар бичсэн юм. Тухайлбал “Шинжлэх ухаан, амьдрал” сэтгүүлийн 1988 оны 5-р сарын дугаарт Ж.Пүрэвсүрэн “Хөвсгөл: ирээдүйн үүднээс” гэсэн өгүүллийг дурдаж болох юм. Тэрээр 1972 онд ЮНЕСКО-гос баталсан Дэлхийн байгалийн өвийн жагсаалтад батлагдсан Хөвсгөл нуур орчмын геологийн тогтцыг үүнд оруулах саналыг тавьжээ (Пүрэвсүрэн 1990, 7). Монголын сэтгүүлчдийн холбооны гишүүн Т.Баасансүрэн, П.Пүрэвсүрэн, Д.Цэдэн-Иш зэрэг сэтгүүлч зохиолчид Хөвсгөлийн хөдөлгөөнд идэвхтэй оролцож бүтээл туурвилаа зориулж байв (Баасансүрэн 2009, 12) 1989 оны 1-р сарын 30-нд

⁶⁵ (МАХН-ын архив Хөмрөгний дугаар 4, Дансны дугаар 37 ХН дугаар 24 он 1987 77-79-р хуудас)

болсон Байгаль, орчныг хамгаалах яамны удирдах ажилтны үйлдвэрлэлийн зөвлөгөөн болов. Зөвлөгөөнд Байгаль орчны яамны сайд У.Мавлетийн илтгэлд “1988 онд төвийн сонин хэвлэлд байгаль, орчны талаар нийтлэгдсэн 200-гад материалыг нэг бүрчлэн судлан үзэхэд арга хамжээ авч хэрэгжүүлэх 500 гаруй чухал санал санаачилга дэвшигдсэн байна” гэжээ⁶⁶. Үүнээс харахад шинээр байгуулагдсан яамны хувьд иргэдээс олон чухал санал шаардлага хүсэлт хүлээн авч байжээ. Байгаль орчны яам 1989 оны байдлаар системийн хэмжээгээр 2112, үүнээс яамны төв аппарат 208 санал, өргөдөл, гомдол хүлээн авч шийдвэрлэжээ. “Тайлант хугацаанд Байгаль орчны яамны үйл ажиллагаатай холбогдсон асуудлаар төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр 80 гаруй санал шүүмжлэл гарснаас Байгаль, орчныг хамгаалах яам 60 асуудлыг шийдвэрлэж хариу өгсөн бөгөөд үлдсэн 20 асуудлыг холбогдох яам, тусгай газарт тавьж шийдвэрлүүлэв” гээд “ихэнх нь ой, ан байгаль, хамгаалах талаар тавьсан санал мэдээлэл байсан бөгөөд түүний дагуу газар дээр нь шалгалт хийж гарсан зөрчил дутагдлыг арилгах, таслан зогсоох, нөхөн төлбөр тавих, зарим оновчтой саналуудыг хүлээн авч хэрэгжүүлэх ажлуудыг зохион байгуулж ирлээ”⁶⁷. Иргэд хөдөлмөрчдийн байгаль орчныг хамгаалах идэвх санаачилга яамтайгаа холбогдсоноор бодитой ажил хэрэг болж иргэдийн оролцоон дээр суурилсан байгаль орчныг хамгаалах тогтолцооны үндэс тавигдав.

1989 онд Ц.Балдорж “Хүйн холбоотой Хөвсгөл, Байгал” гэсэн дараагийн өгүүллийг тэрээр хэвлүүлсэн юм (Балдорж, Хүйн холбоотой Хөвсгөл, байгал хоёр 1989). Энэ өгүүлэлдээ “Олон улсын зохиолчдын “Байгалын хөдөлгөөний” ээлжит уулзалтын талаар мэдээлэл өгөөд улмаар “Бива нуураа хамгаалахын төлөө “Загасчдын хөдөлгөөн”, “Гэрийн эзэгтэй нарын хөдөлгөөн” гэхчлэн олон янзын хэлбэрээр тэмцэж байна” гэжээ. Хөвсгөлийн хэмээх оюутны хөдөлгөөн үүсэхэд энэ өгүүлэл нь уриалан дуудсан, бүр загвар болж өгч байжээ. Уг хөдөлгөөнд олон зохиолч сэтгүүлч нар нэгдэж Хөвсгөлтэй холбоотой бүтээл туурвиж байснаас Монголын радиогийн хөдөө аж ахуйн редакцын редактор П.Баярсайхан манай улсаас анх удаа “Болор тунгалаг Хөвсгөл бохирдох ёсгүй” гэсэн цуврал нийтлэлээрээ НҮБ-ын шагнал хүртсэн (Норовсүрэн 2012, 27).

Улмаар Ц.Балдорж гурав дахь өгүүлэлээ 1989 оны 11-р сард “Үнэн” сонинд гаргав, түүний сүүлчийн өгүүлэл нь “Далай ээжтэй золгохын ерөөл тавив” гэсэн өөдрөг нэрээр төгсгөв (Балдорж, Далай ээжтэй золгохын ерөөл тавив 1989) Дөрөвдөх өгүүллийг “”Далай ээжийг” цаазлахаар зэхэж байна” гэсэн сүүлчийн өгүүллийг гаргав (Балдорж, "Далай ээжийг" цаазлахаар зэхэж байна 1989). Үргэлжлэл нь дараагийн дугаарт гарна.

Ном зүй

- Beissinger, Mark R. 2002. *Nationalist Mobilization and the Collapse of the Soviet State*. Cambridge : Cambridge University Press.
- Dawisha, Karen., Parrott, Bruce. 1997. *The consolidation of democracy in East-Central Europe*. Cambridge: United Kingdom at the University of Press, Cambridge.
- Doug Adams., John D. McCarthy., Mayer N.Zald. 1996. *Comparative Perspectives on Social Movement*. New York: Cambridge University press.
- Juan J.Linz., Alfred Stepan. 1996. *Problems of Democratic transition and consolidation*. Baltimor, Maryland: The John Hopkins University.
- Rainey, B. Thomas. 1991. "Siberian writers and the Struggle to Save lake Baikal." *Environment history review* 46-60.
- Sanders, Alan. 1996. *Historical dictionary of Mongolia*. Lanhan, Md., & London: The Scarecrow Press, Inc.
- Zaharchenko, Tatiana. 1990. "The Environmental Movement and Ecological law in the Soviet Union: The process of Transformation." *Ecological law quarterly* 455-465.
- Zakharchenko, Tatiana. 1990. "The Environmental Movement and Ecological law in the Soviet Union: The process of transformation." *Ecology and law quarterly* 435.
- Айтматов, Чингиз. 1989. *Цаазын тавцан*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.

⁶⁶ (Хөмрөгний дугаар 407, Дансны дугаар 1 ХН дугаар 35, он 1989 40-р хуудас)

⁶⁷ (Хөмрөгний дугаар 407, Дансны дугаар 1 ХН дугаар 35, он 1989 73-р хуудас).

- Алтанхуяг, Н. 2012. *Оргил өөд...* Улаанбаатар: Migmaprinting.
- Амарсанаа, С. 2011. *Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд*. Улаанбаатар: МН-Технологи.
- Баасансүрэн, Т. 2009. *1990 оны ардчилсан хувьсгал ба монгол дахь чөлөөт хэвлэлийн хөгжил, түүний цаашдын төлөв хандлага*. Улаанбаатар.
- Балдорж, Ц. 2008. "Далай ээж" маань цаазын тавцанд. Улаанбаатар: Соёмбо принтинг.
- Балдорж, Ц. 1987. "Далай ээж маань цаазын тавцанд." *Үнэн*.
- 1989. "'Далай ээжийг' цаазлахаар зэхэж байна." *Үнэн*, Арван нэгдүгээр сарын.
- 1987. "Далай ээж маань цаазын тавцанд." *Үнэн*, Есдүгээр 29: 1-4.
- 1989. "Далай ээжтэй золгохын ерөөл тавив." *Үнэн*, Арван нэгдүгээр сарын: 2.
- 1989. "Хүйн холбоотой Хөвсгөл, байгал хоёр." *Үнэн*.
- Балдорж, Ц., Ногояа, Ё., Цэрэнжав, Д. 1989. "Өөрсдийгөө өөрчилж, сэтгэлгээгээ шинэчлэх шаардлага." *Үнэн*, Тавдугаар сарын 24: 2.
- Баркманн, У. 2008. *Орчин цагийн монголын тухай өгүүлүүд*. Улаанбаатар: Адмон.
- Батмөнх, Ж. 2001. *Хүч хэрэглэж хэрхэвч болохгүй*. Улаанбаатар: Интерпресс.
- Бат-Очир, Б. 1988. "Оюутны өөртөө тавих шаардлага." *Үнэн*.
- Батхшиг, Б. 2009. *Ардчилал, шинэчлэлийн үйлсэд*. Улаанбаатар: Адмон.
- Батчулуун, Л. 1991. *Үнэн*, Наймдугаар сарын 20: 1-4.
- Болдбаатар, Ж ба Морозова, Ирина. 2013. *Өөрчлөн байгуулалт Төв Азийн орнуудын нийгмийн амьдралд нөлөөлсөн нь*. Улаанбаатар: Улаанбаатарын их сургуулийн хэвлэл.
- Буйлов, Анатолий. 1989. *Их нүүдэл*. Москва: Радуга.
- Бүдээхүү, Т. 2010. *Өнгө төрх*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Бүрэнтогтох, Х. 2014. *Ламжав: Ер нь Ардчилсан социалист хөдөлгөөнийг байгуулах гээд идэвхтэй оролцсон хүн нь манай Улаанхүү байгаа юм*". Арван нэгдүгээр сарын 16. Accessed Тавдугаар сарын 20, 2016. <http://www.info.mn/news/57514.htm>.
- В.Распутин. 1990. *Дурсаж яваарай*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Ганбат, Х. 1988. "Оюутны даваа." *Үнэн*, Арван нэгдүгээр сарын 5: 3.
- Горбачев, М.С. 2013. *Бүх юм өөрийн цаг хугацаатай*. Улаанбаатар: Монсудар.
- 1987. "Хэлсэн үг." *Үнэн*, Долдугаар сарын 28: 1.
- Гэндэндарам, Ж. 1990. "Цуурхал." *Намын амьдрал*, Нэгдүгээр: 71-73.
- Даш, С. 2008. *Монголын залуучууд III боть*. Улаанбаатар: Мөнхийн үсэг.
- Даш, Я. 187. "Далай ээжээ хамгаалья." *Үнэн*, Хоёрдугаар сарын 7: 4.
- Жамъянсүрэн, Ч. 2005. *Цагаан морин жилийн хөх хувьсгал*. Хөвсгөл.
- Жасрай, П. 1988. "'Далай ээж цаазын тавцанд'." *Үнэн*, Нэгдүгээр сарын 14: 3.
- Заяат, У. 1988. "'Далай ээж маань цаазын тавцанд'." *Үнэн*, Нэгдүгээр сарын 14: 3.
- Ламжав, Д. 2015. "Анх намайг Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэх санал гарч байлаа. Ярилцлага." *Үндэсний шуудан*, Есдүгээр сарын 28: 6.
- Лхагва, Т. 2019. *Ардчиллын замнал: алдаа-оноо, сургамж-сорилт Боть 1*. Улаанбаатар: Сэлэнгэ пресс.
- Мавлет, У. 1989. "Төрөлх байгалиа хайрлан хамгаалья." *Намын амьдрал*, Есдүгээр сарын.
- 1989. "Байгаль орчин, өнөөгийн зорилт." *Үнэн*, Хоёрдугаар сарын 16: 3.
- 2008. *Хөдөлмөрөөр жигүүрлэсэн он жилүүд*. Улаанбаатар: Сорхон цагаан.
- МАХН. 1986. *МАХН-ын XIX их хурал*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
1988. *Монгол Ардын Хувьсгалт Намын Төв Хорооны V бүгд хурал*. Улаанбаатар.
- МУИС. 2007. *Математик, компьютерийн сургуулийн түүхэн замнал (1942-2007)*. Улаанбаатар: Бемби сан.
- Намжим, Т. 1987. *БНМАУ-ын үйлдвэрлэх хүчин, эдийн засгийн асуудал*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Боть 1. *Монгол улсын эдийн засаг*. Улаанбаатар.
- 1996. *Монголын эрт ба эдүгээ*. Улаанбаатар.
- Намсрай. 2007. *Өөрчлөн байгуулалтыг монгол ухаан түшиглэж хийцгээе*. Улаанбаатар: Адмон.
- Нацагдорж, В. 1998 дугаар 2.4. "Элбэгдорж бол үүрээ засчихсан салхич шувуун." *Парламент 2*.
- Норовсүрэн, Л. 2012. *Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм*. Улаанбаатар: МУИС-ийн хэвлэх үйлдвэр.
- Очирбат, П. 1996. *Тэнгэрийн цаг*. Англи: Дэ Баф пресс.
- Оюунгэрэл, А. 1990. "Уншигч сонин уншигч." *Утга зохиол урлаг*, Нэгдүгээр сарын 1: 2.
- Оюунгэрэл, Ц. 2012. *Миний хобби*. Улаанбаатар: Адмон.
- Пүрэв, Ж. 2004. *Халуун яриа*. Улаанбаатар.
- Пүрэвсүрэн, Ж. 1990. "Нийт хүн төрөлхтөний өв." *Үндэсний Дэвшил*, Есдүгээр сарын 1: 1-8.
- Содном, Д. 2003. *Амьдрал бодол*. Улаанбаатар: Интерпресс.
- Сувдаа, С. 2019. *Эрдэнэтийн ардчиллын бүрэн түүх*. Улаанбаатар.
- сурвалжлагч, Манай. 1990. "Хөвсгөл нуурын сорви арилаггүй байна." *Ертөнц*, Есдүгээр сарын 26: 3.
- сургууль, Хууль зүйн. 2010. *Монголын хуульчдын эрдмийн өлгий*. Улаанбаатар: Адмон.

- Сүхбаатар, Д., Эрдэнэцогт, С. 2019. *Монголын дээд боловсрол, оюутны байгууллагын түүхэн хөгжлийн тойм ба цагаан морин жилийн хувьсгал*. Улаанбаатар.
- Түдэв, Б. 1990. "Цөөн ч гэсэн үндэстэн." *Үндэсний дэвшил*, Наймдугаар сарын 4: 1-8.
- Түдэв, Л. 1990. *Асуудал? Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар*.
- Үнэн. 1988. "БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд." *Нэгдүгээр сарын 2: 1*.
- Үнэн. n.d. "Уран бүтээл, өөрчлөн байгуулалт."
- Үнэн. 1988. "Байгал, Хөвсгөл нуурын байгалийн зохицлыг хамгаалах асууудлаар монгол, зөвлөлтийн сэтгүүлчдийн хийсэн дугуй ширээний уулзалтанд оролцогчдын уриалга." *Үнэн*, Долдугаар сарын 7: 3.
- . 1988. "Зөвлөлт, Монголын зохиолчдын уулзалт." *Үнэн*, Долдугаар сарын 12: 4.
- хороо, МАХН-ын Төв. 1987. *МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн хороо.
- . 1966. *Монгол Ардын Хувьсгал намын программ*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар.
- Цэдэн-Иш, Д. 1990. "Хөвсгөл нуур бидэнд ганц л байна." *Үнэн*, Долдугаар сарын 31: 4.
- Цэрэннадмид, Ж. 1991. "Байгаль хамгаалагч Түдэв." *Ертөнц*, Тавдугаар сарын 20-30: 1-8.
- Чойжилжав, Х. 1987. "Үнэн." *Хөдөлмөрчдийн захидал*, Дөрөвдүгээр сарын 5: 3.
- Чойсамба, Ч. 2011. "Экологийн сэтгүүл зүй ба цөлжилтийн сэдэв." *Сэтгүүл зүй* 34-41.
- Чулуунбаатар, С. 2010. *Нар зөв тойрог*. Улаанбаатар.
- . 2009. *Нар зөв тойрог*. Улаанбаатар: Адмон.
- Элбэгдорж, Ц. 2022. *Ардчилалд хүрсэн зам: бодит түүх*. Тавдугаар сарын 2. <http://ebidiary.mn/1989/11/>.
- Энхбаяр, П. 1989. "Залуу үеийнхний улс төрийн индэр." *Үнэн*, Долдугаар сарын 29: 2.
- Энхтүвшин, Д. 2013. "Р.Хадбаатар: Сэтгүүлч бол нийгмийг эмчилдэг үзэг барьсан эмч юм." *Өнөөдөр*, Арван хоёрдугаар сар 13: А4.
2011. *Эрдэнэтийн ардчилал 20 жил*. Эрдэнэт.
- Эрдэнэцогт, Мөнхтөр. 2009. *Эрх чөлөөний эрэлхийлэлд*. Улаанбаатар.